



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ НЭХЭМЖЛЭН
ХАМГААЛАХ НЬ

ӨМГӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН
ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар
2006 он

DDC
342.085.5
D-485

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, хувилахыг хүсвэл
Нээлттэй Нийгэм Форумын хаягаар хандан зохих зөвшөөрөл авна.

Хаяг:
Жамъян Гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48
Монгол улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857

Гарын авлагыг сонирхсон байгууллага хувь хүмүүст
хямдралтай үнээр худалдана.

ISBN 978-99929-2-011-4

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
Нэг. НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ НЬ	1
1.1. Стратегийн өмгөөлөл гэж юу вэ?	2
1.2. Стратегийн өмгөөллийн ач холбогдол, үр нөлөө	3
1.3. Стратегийн өмгөөлөл нь цогц стратегийн нэг хэсэг болох нь	4
1.4. Стратегийн өмгөөллийн үүсэл, хөгжил	5
1.5. Стратегийн өмгөөллийн зарим туршлагауд	6
Хоёр. МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН МЕХАНИЗМ БА ТУРШЛАГА	7
2.1. Монгол Улсад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн механизм	8
2.2. Монгол Улсад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа: анхны алхам ба сорилтууд	9
Гурав. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ	10
3.1. Стратегийн өмгөөллийг сонгох нь	11
3.2. НҮБ-ын хүний эрхийг хамгаалах механизмийг ашиглах нь	12
3.3. Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалдаг байгууллага	13



ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форумгаас эрхлэн уншигч танд энэхүү товхимолыг толилуулахаар бэлтгэсэнтэй анхлан танилцах завшаан надад тохиов. Энэ номоор дамжин “стратегийн өмгөөлөл” гэсэн шинэ ойлголт, мэдлэг Монгол улсад нэвтрэн орж байна. Монголчууд бид тодорхой хүний, үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлын өмгөөллийг сайн мэднэ. Тэгвэл нийтийн эрх ашгийг хамгаалахын төлөө хийгддэг өмгөөлөл гэж байдаг ажээ. Ийм өмгөөллийг стратегийн өмгөөлөл хэмээн дэлхийн олон улс оронд нэрлэж заншжээ. Энэхүү өмгөөлөл хөгжсөн улс оронд өмгөөлөл нь нийгмийн нийгмийн амьдралд бүтээлч үйл ажиллагаа болон хувирч, олон хүний эрх ашгийг хөндсөн асуудлууд шударгаар шийдвэрлэгдэн хүний эрх, эрх чөлөө жинхэнэ ёсоор хангагдах бодит боломж бүрддэг байна. Стратегийн өмгөөлөл нь шүүх хуралдааны танхимд явагдаж, шүүхийн шийдвэрийн хүчээр зөрчигдсэн эрх сэргээн тогтоогдох төдийгүй хууль сахиулах байгууллагын тогтолцоогоор барахгүй хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх асар их чадамжийг агуулдаг болохыг энэ номоос олж мэдэх болно.

Стратегийн өмгөөлөл нь өмгөөллийн нэр хүндийг үлэмж дээшлүүлнэ. Цөхөрсөн, ядарсан, учраа олохгүй байгаа олон хүмүүст ач тусаа өгч, хүмүүс ирээдүйдээ итгэл төгс амьдрах сэтгэлийн тэнхээг өгөх болно.

Стратегийн өмгөөллийн асуудлаар Монгол Улсад зам нээж байгаа эл номыг буй болгоход “Хүний эрх, хөгжил төв” төрийн бус байгууллага ихээхэн үүрэг гүйцэтгэснийг зориуд тэмдэглэж байна.

Монгол улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөө оюуны үнэт зүйлсийг хөгжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж ирсэн Нээлттэй Нийгэм Форумас эл номыг бэлтгэх санааг дэвшүүлж, түүний боловсруулалт, хэвлүүлэлтэд дэмжлэг туслалцаа үзүүлсэнд гүн талархал дэвшүүлж байна.

Өмгөөлөгч, академич,
хууль шинжлэх ухааны доктор, профессор
С. Нарангэрэл

БҮЛЭГ 1

Нийтийн эрх ашгийг Нэхэмжлэн хамгаалах нь

- Энэхүү бүлэгт нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах зорилготой стратегийн өмгөөллийн ойлголт, ач холбогдол, үр нөлөөний талаар танилцуулна. Түүнчлэн, стратегийн өмгөөллийн үүсэл, хөгжил болон бусад улс орнуудын тухайлбал, АНУ, Өмнөд Америк, Зүүн Европын туршлагаас толилуулав.

1.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Уламжлалт ойлголтоор өмгөөлөгчид нь тодорхой үйлчлүүлэгчийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэдэг. Эдгээр өмгөөлөгчид нь уг хэрэгт холбоотой хууль тогтоомжинд шинжилгээ хийж, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалж ажилладаг. Түүнчлэн зарим хуульчид тухайн нэг үйлчлүүлэгчийн сонирхлыг хамгаалахаас гадна, өргөн хүрээний үр нөлөө үзүүлэхүйц өмгөөллийн үйл ажиллагааг явуулдаг. Өөрөөр хэлбэл, тулгарсан асуудлаа шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтэй иргэдийг төлөөлөн хууль эсвэл түүнийг хэрэглэж буй практикийг өөрчилж, нийгэмд нөлөөлөх зорилготой өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү өмгөөллийг стратегийн өмгөөлөл гэдэг байна. Өөрөөр хэлбэл, стратегийн өмгөөлөл нь нийгэм, эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлд чиглэсэн өмгөөллийн үйл ажиллагаа юм. Энэхүү өмгөөлөлд нийтийн эрх ашгийг хамгаалсан өөр бусад үйл

¹ Энэхүү бүлгийг Эдвин Рэкош “Who Defines the Public Interest?” SUR ; PILI Paper No. 1 by Public Interest Law Initiative (Budapest 2005) эх сурвалжууд дээр тулгуурлав.

² Test-case гэдгийг шалгуур хэрэг гэж орчуулан хэрэглэв.

ажиллагааг хамруулан ойлгодог. Стратегийн өмгөөллийн хэргийг сонгохдоо тухайн асуудал нь нийтийн эрх ашгийг хөндсөн, өөрөөр хэлбэл, хоёр хувь этгээдийн хоорондын зөрчил бус, ирээдүйд жишиг болгон ашиглаж болох, олон нийтийн болоод хэвлэл мэдээллийн анхаарал татах; хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийн заалтыг ашиглаж болох зэрэг шалгуурыг хэрэглэдэг байна.

Стратегийн өмгөөллийг мөн “нөлөөллийн өмгөөлөл”, “шалгуур”² “хэргийн өмгөөлөл” эсхүл “нийтийн ашиг сонирхлын өмгөөлөл” гэх зэргээр нэрлэх явдал бий.

Нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг нэртэй өмгөөлөгч, АНУ-ын Колумбын Их сургуулийн профессор Гринберг нийтийн эрх ашгийн өмгөөлөх ажиллагаа нь эрх зүйн тогтолцоонд хэрхэн нөлөөлдөгийг хоёр байдлаар тодорхойлсон. Нэгд, стратегийн өмгөөлөл нь хуулийг тайлбарлах хэрэгцээ шаардлагыг шүүхийн тогтолцоонд таниулж ойлгуулдаг. Хоёрт, стратегийн өмгөөлөл нь төр засгийн буруутай үйл ажиллагааг засах, уг ажиллагаанд өртөгдөж, хохирсон хүмүүст туслахын тулд хуулийн институт, хууль, дүрэм, гэрээ хэлэлцээрийн эрх хэмжээний хүрээг эргэн харж дахин тодорхойлох, эсвэл баталгаажуулахыг шүүхээс шаарддаг. Үүнээс гадна, нийтийн эрх ашгийг хамгаалсан боловч амьдрал дээр хэрэгждэггүй, хэрэглэгдэггүй хууль, дүрэм, журмыг шүүхийн практикт хэрэглэдэг болгохын тулд стратегийн өмгөөллийн ажиллагааг хэрэгжүүлж шүүхэд нөлөөлдөг байна.

Стратегийн өмгөөллийн тухай эдгээр ойлголт нь АНУ-ын олон нийтийн эрх ашгийн өмгөөллөөр ажилладаг хуульчдын туршлагаас урган гарсан юм. Европын хүний эрхийн шүүх болон дотоодын үндсэн хуулийн шүүх зэрэг механизмыг ашиглан ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг Европын хуульчдын ажиллагаа бас үүнтэй төсөөтэй байдаг. Мөн Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Энэтхэг улсад хуульчид, өмгөөлөгчид нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна.

Стратегийн өмгөөлөл нь үндэсний болон олон улсын шүүхэд хэрэг үүсгэхээс гадна олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх,

³ Олон улсын бага хурал, Колумбийн Их Сургуулийн Хуулийн сургууль, NAACP-Legal Defence Fund, 1991

өөрчлөлт хийхийн төлөөх хүчтэй дэмжлэгийг бий болгох үйл ажиллагааг хамруулдаг. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан өмгөөлөл нь нийгэм ба хуулийн хоорондын харилцаа, нөлөөллийг харуулдаг. Нэг талаас олон нийтээс илэрхийлж буй эрх зүйн шинэтгэл хийхийг шаардсан хэрэгцээ нь стратегийн өмгөөллийн ажиллагааны шалтгаан болно. Нөгөө талаас хуулийн байгууллагын үйл ажиллагаа нь олон нийтийн эсэргүүцэл эсвэл дэмжлэгийг идэвхжүүлж, эцэст нь нийгмийн болон хуулийн хүрээний өөрчлөлтийг бий болгодог.

Стратегийн өмгөөллийг явуулснаар нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг байгууллагууд нийгмийн өөрчлөлтийн төлөөх хүчин чармайлтын тэргүүн эгнээнд гардаг. Гэхдээ, зөвхөн шүүхээр шийдвэрлүүлсэн ганц нэг хэрэг, шүүхийн ганц шийдвэрээс хамаарч нийтийн эрх ашгийг хамгаалсан кампанит ажил амжилтанд хүрнэ, эсвэл ялагдал хүлээнэ гэдэг нь ховор гэдгийг санах хэрэгтэй. Өмгөөллийн сөрөг үр дүн нь заримдаа таагүй хууль, хууль зүйн практикийг улам баталгаажуулж, ингэснээр уг асуудлыг улам гүнзгийрүүлж, түүнийг цаашдаа амжилттайгаар шийдвэрлэхэд улам бэрхшээлтэй болгож болно. Ихэнх амжилттай хэрэгжсэн кампанит ажлууд нь тавьсан зорилгодоо хүрэхийн тулд маш олон талын арга замыг ашигласан байдаг. Харин өмгөөлөл нь эдгээрийн зөвхөн нэг бүрэлдхүүн хэсэг болдог.

Нийтийн эрх ашгийг хамгаалах хэрэг дээр олон нийтийн дэмжлэг авах нь их чухал. Европын эх газрын эрх зүйн тогтолцоо давамгайлсан орнуудад шүүхийн нэг шийдвэр нь бусад шүүхийг ижил шийдвэр гаргахад хүргэдэггүй. Иймээс шүүхээс гарах шийдвэрүүдэд нөлөөлөх нэг хүч нь олон нийтийн шахалт юм. Түүнчлэн үйл ажиллагаагаа нийтэд түгээхдээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл сурталчилгааны чиглэлээр ажилладаг байгууллагатай хамтран ажилладаг байна.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааг дараах үндсэн стратегийн хүрээнд хэрэгжүүлнэ.³ Үүнд:

Шүүхээр хамгаалах стратеги. Энэ нь нийтийн буюу тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалан шүүхэд хандах.

Хуулийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх стратеги. Шүүхээр амжилттай шийдүүлсэн анхны жишиг хэргүүдийг ашиглан хуулийн

хэм хэмжээ, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг өөрчлөх. Үйлчилж байгаа хуулийн хүрээнд өмгөөллөөр зөрчигдсэн эрхийг сэргээх, түүний хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагаа юм.

Бодлогын шинжтэй стратеги. Шинэтгэл нь зөвхөн хуулийн тогтолцоо эрх зүйн хүрээгээр хязгаарлагдахгүй улмаар нийгмийн бусад хүрээг хамран төрийн болон нийгмийн бүлгүүдийн харилцан хамаарлыг өөрчлөх бодлогод хүргэх.

1.2. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ҮР НӨЛӨӨ

Стратегийн өмгөөлөл нь хууль тогтоох үйл явц болоод олон нийтийн санаа бодол улмаар эрх зүйн болон нийгмийн шинэчлэлд нөлөөлж чаддаг.

Амжилттай стратегийн өмгөөллийн үр дүнд үйлчлэж буй хуулийн заалтуудын хэрэгжилт дээшилж, төр хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд түлхэц болдог. Мөн түүнчлэн бүх шатны шүүхүүд тодорхой хуулийг хэрэглэж, тайлбарлахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

АНУ-ын нийтийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын холбоо болох Шударга ёсны төлөө сүлжээг үндэслэгч Нан Арон нь өмгөөллийн үйл ажиллагааны дагуу хүрч болох үр дүнг 4 ангилалд хуваасан. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийг хангах
2. Хуулийг хэрэглэх ба тайлбарлах
3. Нийгмийн институтыг шинэчлэх
4. Нийгэм, улс төрийн өөрчлөлтөнд уриалан дуудах

1. Хуулийн биелэлтийг хангах

Маш олон стратегийн өмгөөллийн хэрэг нь огт хэрэгждэггүй эсхүл буруу хэрэгждэг хуулийн заалтыг зөв, нэг мөр биелүүлдэг болгох асуудлыг шүүхийн өмнө гаргаж тавьдаг. Хүний эрхийн асуудлаарх шүүхийн шийдвэрүүд нь ихэнхдээ төрийн байгууллагуудаас иргэдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардсан байдаг.

Жишээлбэл, байгаль орчны болон, хэрэглэгчдийн эрхтэй холбоотой шийдвэр нь нийгмийн эрүүл мэндийн зохицуулалтыг хянах, хууль бус бизнесийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх асуудлыг шийдвэрлэсэн байдаг. Ногоон хөдөлгөөн хэмээх Хорватын байгаль орчны байгууллагын хуулийн чиглэлээр хийсэн үйл ажиллагаануудын үр дүнд уул уурхайн зарим компаниудад Засгийн Газрын болон орон нутгийн зөвшөөрөл олгохыг зогсоосон байдаг.

Ийм хэргүүд нь нийгмийн бодлогын ба эрх зүйн шинэтгэлийн кампанит ажлын амжилтанд маш чухал үүрэгтэй юм.

2. Хуулийг хэрэглэх ба тайлбарлах

Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад өргөн хүрээний бодлогын хуулиудыг хууль тогтоох байгууллага батлан гаргадаг ба эдгээрийг тайлбарлаж, тодорхой нөхцөл байдалд тохируулан хэрэглэх үүргийг шүүх хүлээдэг. Харин англо-саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад, ерөнхий хуулийн заалтууд, Үндсэн хуулийн хамгаалалтуудыг тодорхой нөхцөлд хэрхэн хэрэглэх талаар тайлбар гаргахад шүүхийн үүрэг их байдаг. Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүх болон олон улсын шүүхийн шийдвэр, дүгнэлтүүдийг хууль тогтоох, гүйцэтгэх шүүх эрх мэдлийн байгууллагууд даган мөрдөх ёстой ба эдгээр нь тухайн улс орны бусад бүх шатны шүүхүүд хуулийг хэрхэн хэрэглэх, тайлбарлахад нөлөөлж байдаг. Дээрх шүүхүүдэд хийсэн стратегийн өмгөөллийн хэрэг амжилттай болсон тохиолдолд, тухайн хэрэгтэй холбоотой ерөнхий асуудалд нөлөөлөх магадлал их байдаг. Ийм байдлаар, Дээд шүүх болон Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн шийдвэрийг шүүхийн тогтолцооны бусад байгууллагууд тусган авч дагаж мөрддөг байна.

Түүнчлэн бүсийн болон олон улсын механизмийг ашиглаж болно. Тухайлбал, Европын хүний эрхийн шүүхэд хандан стратегийн өмгөөллийн хэргийг шийдвэрлүүлж болдог. Ийм шүүхийн шийдвэр нь тухайн нэг оронд төдийгүй, ижил асуудал бүхий өөр оронд ч нөлөөлөх боломжтой. Хэрвээ тухайн хэрэг нь үндэсний хууль тогтоомж олон улсын эрх зүйтэй хэрхэн нийцэж байгаа асуудлыг хөндсөн бол гарсан шийдвэр нь тухайн улсын хууль тогтоомжийг шууд өөрчлөхөд хүргэж болно.

3. Нийгмийн институтыг шинэчлэх

Стратегийн өмгөөллийн шийдвэр нь институтын өөрчлөлтийг авчирдаг. Жишээлбэл сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад аюултай нөхцөл байдал илэрсэн учраас АНУ-ын шүүхээс тус байгууллагын бодлого, үйл ажиллагааг өөрчлөх шийдвэр гаргаж

Словакийн Өмгөөллийн жишээ: Ой хамгаалах асуудлаар

Словакийн ой хамгаалах ВОЛФ хэмээх хөдөлгөөний хөдөө аж ахуйн яамны эсрэг үүсгэсэн хэрэг нь амжилтгүй болжээ. Тэд ойн асуудлыг зохицуулах төлөвлөгөөний асуудлыг хэлэлцэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орох гэсэн оролдлого хийсэн байв. Дээд шүүх тэдний нэхэмжлэлийг няцаасан боловч энэ хэрэг нь Словакийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орох байгууллага хувь хүнийг шалгаруулах шалгуурыг өргөн хүрээгээр тайлбарлах явдлыг баталгаажуулахад тустай болсон байна. Ингэснээр иймэрхүү бусад ажиллагаанд ТББ-уудыг оролцуулах явдлыг дэмжинэ гэж ВОЛФ үзсэн байна.

байсан байна. Мөн түүнчлэн, хорих газарт нүүрлэсэн аюултай, хэрцгий нөхцөл байдлыг шүүхээр шийдвэрлэсний үр дүнд шоронгийн хэт их дүүргэлтийг даамжруулсан бусад ажиллагааг эцэс болгох үүрэг АНУ-ын шүүхээс тогтоожээ.

4. Нийгэм, улс төрийн өөрчлөлтөнд уриалан дуудах

Стратегийн өмгөөллийн ажиллагаа нь нийгмийн санаа бодлыг өөрчлөх, түүнд нөлөөлөх зорилготой байдаг юм. Энэхүү өөрчлөлтийг дэмжигчид нь хууль, шүүхийн практик ажиллагаанд болон нийгэмд бүхэлд нь нөлөөлөхийн тулд шүүхийнхэн болоод олон нийтийн анхаарлыг тухайлсан нэг асуудалд хандуулахад чиглэсэн ажиллагааг шүүхийн танхимд явуулдаг.

Нийтийн эрх ашгийг хамгаалсан ажиллагаа нь жирийн иргэд олж авахад хүндрэлтэй байдаг баримт бичгийг гарган тавьдаг.

Болгарын Өмгөөллийн жишээ: Цыган иргэдийн асуудлаар

Болгар улсад Хельсинкийн хороо гэдэг байгууллагаас Дмитри Джевизовын асуудлаар Пловдив хотын нэгэн хувийн кафены эсрэг зарга мэдүүлсэн. Кафены эзэнг цыган хүмүүст үйлчлэхээс татгалзсан явдалд буруутган түүнд шийтгэл оногдуулаагүйн төлөөх хариуцлагыг хотын захиргаа хүлээх ёстой гэж нэхэмжлэл гаргажээ. Хэдийгээр, энэ хэрэг шийдвэрлэгдээгүй хэвээр байгаа төдийгүй шүүхийн танхимд ялалтанд хүрэх найдвар багассан ч нэхэмжлэгч байгууллага нийтийн ашиг сонирхлын төлөөх зорилгодоо хүрч чадсан юм. Учир нь тус кафе одоо бүх үйлчлүүлэгч нарт үндэс угсаа харгалзалгүйгээр үйлчилдэг болсон аж.

Төрийн байгууллагын баримт бичгүүд, ажилтнуудтай хийсэн ярилцлага, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааны талаархи мэдээллүүд зэрэг иргэд олж мэдэхэд бэрхшээлтэй мэдээллийг нийтэд ил болгодог. Ингэж мэдээллийг дэлгэн тавих замаар шүүхэд хүлээгдэж байгаа хэргийг дэмжих нийгмийн сонирхлыг бий болгож, өөрчлөлтөнд хүргэхэд шахах олон нийтийн хүчийг нэмэгдүүлнэ. Иймээс, стратегийн ач холбогдолтой хууль зүйн асуудлыг гаргаж ирснээр цаана нь байгаа гол асуудалд хүмүүсийн анхаарлыг хандуулж, улмаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, өөрчлөлт хийх хэрэгцээ шаардлагыг илүү ихээр ойлгож мэдэрдэг. Нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг байгууллагууд нь өмгөөллийг дэмжсэн ажиллагаа зохион байгуулж, олон нийтэд боловсрол мэдлэг олгож, тухайн хэргээр хөндөгдөж байгаа нийгмийн асуудалд нийтийн анхаарлыг хандуулж, өөрчлөлт хийхэд хувь нэмэр болох хэлэлцүүлгийг өрнүүлэхэд чухал үүрэгтэй ажилладаг.

Стратегийн өмгөөлөл хийхэд тухайн нийгмийн улс төрийн дэглэм, шүүхийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйл чухал нөлөөтэй байдаг. Улс орон бүрийн дотоодын нөхцөл байдал өөр учраас стратегийн өмгөөллийг нэг загвараар дэлхий нийтэд хэрэглэх боломжгүй юм. Гэхдээ шилжилтийн болон шинээр ардчилал тогтоосон орнуудад хүний эрхийн стратегийн өмгөөлөл хийх

нийтлэг хэрэгцээ шаардлага байдаг. Тухайлбал, стратегийн өмгөөлөл нь ихэвчлэн нийгэмд байгаа тэгш бус байдлын өргөн хүрээний дүр зургийг тодорхойлоход тустай жишиг хэргийг гаргаж ирснээр иргэдэд хууль ёсны эрхийг нь эдлүүлж, шинэ эрхийг тунхаглан гаргаж, хүнд суртлыг өөрчилж, нэгдмэл зорилгын төлөө ажиллах холбоо сүлжээг хөхүүлэн тэтгэж чаддаг юм. Стратегийн өмгөөлөл нь дараах зорилгоор түгээмэл ашиглагддаг:

- Шударга бус эрх зүйн тогтолцоотой улс орнуудад өмгөөллийн ажиллагаа нь уг тогтолцооны алдаа дутагдал, тэгш бус байдлыг баримтжуулж ил тод болгодог. Шүүхийн нэхэмжлэл эцсийн дүндээ амжилтгүй болох магадлалтай байсан ч хуулинд байгаа шударга бус байдлыг баримтжуулах, ингэснээрээ түүнийг ил гаргахын тулд ТББ-ууд өмгөөллийг ашигладаг.
- Хуулийг хэрэгжүүлэх үйл явц нь хуульчлагдсан эрхийг зөрчиж байвал, өмгөөлөл нь тэдгээр саад тотгортой тулж ажиллах замаар өөрчлөлт хийдэг.

Хууль тэгш биш хэрэгжиж байгааг шийдвэрлэхийн тулд өмгөөллийн аргыг хэрэглэдэг. Зарим оронд тодорхой бүлэг хүмүүсийн хуульчлагдсан эрхийг хэрэгжүүлдэг мөртлөө бусад хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрдөггүй.

- Ардчилсан дэглэмд шилжиж байгаа шилжилтийн орнуудад, стратегийн өмгөөлөл нь шинэ Үндсэн хуулийн зарчмуудыг хүлээн зөвшөөрүүлэх, хүний эрхийн олон нийтийн мэдлэг

Чили улсад цэргийн дэглэмийн үед “Эв санаат сүсэгтэнгүүд” хэмээх байгууллагаас улс төрийн хоригдлуудыг суллуулахаар шүүхэд зарга мэдүүлдэг байсан байна. Ингэснээр олон жилийн туршид улс төрийн хүчирхийллийн талаар маш чухал баримтуудыг бүрдүүлж чадсан юм. Энэ байгууллагаас шүүхийн танхимд хийсэн ялалт тоотой хэдхэн боловч ингэж их хэмжээний баримтжуулалт хийснээр хожим нь Засгийн Газрын үйлдэж байсан хүчирхийллийн цар хүрээг баримтаар харуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Улс төрийн дэглэм өөрчлөгдсөний дараа, тэдний цуглуулсан баримтууд түүхийн үнэнийг тогтоох шүүхийн үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан юм.

ойлголтыг дээшлүүлэх, жирийн иргэд шүүхэд хандахад зоригжуулан дэмждэг.

Чили улсад цэргийн дэглэмийн үед “Эв санаат сүсэгтэнгүүд” хэмээх байгууллагаас улс төрийн хоригдлуудыг суллуулахаар шүүхэд зарга мэдүүлдэг байсан байна. Ингэснээр олон жилийн туршид улс төрийн хүчирхийллийн талаар маш чухал баримтуудыг бүрдүүлж чадсан юм. Энэ байгууллагаас шүүхийн танхимд хийсэн ялалт тоотой хэдхэн боловч ингэж их хэмжээний баримтжуулалт хийснээр хожим нь Засгийн Газрын үйлдэж байсан хүчирхийллийн цар хүрээг баримтаар харуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Улс төрийн дэглэм өөрчлөгдсөний дараа, тэдний цуглуулсан баримтууд түүхийн үнэнийг тогтоох шүүхийн үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан юм.

- Шүүхийн ажиллагаагаар дамжуулан шүүгчдийн хүний эрхийн ойлголтыг дээшлүүлж, түүнчлэн иргэдэд эрхийн асуудал, хуулийн боломжуудын талаар ойлголт мэдлэг олгодог. Тухайлбал, үндэсний хуулийн боломж бага үед хүний эрхийн олон улсын эрх зүйн шинэлэг, бүтээлч байдлаар хэрэглэх арга байдаг. Өнөө үед шүүхийн тогтолцоонд олон улсын эрх зүйн хэм хэмжээг нийцүүлэн хэрэглэх, мөн шүүгчдэд хүний стандартуудын ойлголтуудыг дээшлүүлэх, сургах үүднээс стратегийн өмгөөлөл явуулах нь чухал байдаг.

Аргентин улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнөөс тэдний эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа явуулсан. 1997 онд хоёр ТББ барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлыг шүүхэд тавьж, шүүхийн байшинд нэвтэрч чадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүний хэргийг шүүхэд нэхэмжилсэн. Шүүхээс Буэнос Айросын бүх шүүхийн байранд тэргэнцэртэй хүн ороход тохиромжтой замтай болохыг шаардсан шийдвэр гарсан. Гэхдээ, шүүхийн энэ шийдвэр нь Буэнос Айросаас бусад газруудад энэ хуулийг хэрэгжүүлэх тухай заагаагүй юм.

Палестиний иргэд нутаг дэвсгэрт нь байгуулагдсан химийн үйлдвэрээс болоод байгаль орчны ноцтой асуудалтай тулгарсан. Тэдгээр үйлдвэрийг Израилийн байгаль орчны хуулиас дайжуулан тэнд байгуулжээ. 1992 онд Хүний эрх байгаль орчныг хамгаалах Палестиний нийгэмлэгийнхэн тэрхүү эзлэгдсэн нутаг дэвсгэрт байдаг Тулкаремын оршин суугчдын нэрийн өмнөөс тэр хортон шавьж устгагч химийн үйлдвэрийг хаалгахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Энэ үйлдвэрийг Израилийн иргэд байгаль орчинд сүйтгэл учруулсны улмаас шүүхийн шийдвэрээр хаалгасны дараа тэд энэ эзлэгдсэн нутаг дэвсгэрт нүүлгэсэн байлаа. Иймээс энэ үйлдвэрлэлийг тус нутгийн цэргийн шүүхэд өгсөн. Тэр үйлдвэрийг Израилийн байгаль орчны хуулийг зөрчиж, үйлдвэрийн бүтээгдэхүүн нь ус, тариалангийн талбай, оршин суугчдын эрүүл мэндийг хохируулж байна гэсэн нотлох баримтыг гаргаж ирсэн бол шүүх дээр хагас ялалт байгуулсан. Учир нь уг үйлдвэрийг хаах шийдвэр гараагүй гэхдээ хортой химийн бүтээгдэхүүн гаргахыг хориглож, үйлдвэрийн ажилчдыг масктай ажиллуулах шаардлага тавьсан. Энэ шүүх ажиллагааны ачаар тэр орчмын байгаль орчны талаарх иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хурал, семинар зохион байгуулж, кино үзүүлж байсан байна. Эцэст нь уг шүүх хурлын алдааны талаар хэвлэгдэж нийтлэгдсэн материалууд нь Засгийн Газрыг байгаль орчны хуулиа адил тэгш хэрэгжүүлэхийг шаардсан шахалт болсон юм.

Хууль нь нийгмийн амьдралд олон талаар нөлөөлдөг бөгөөд нөгөө талдаа нийгмийн амьдралын олон талт үйл явц нь хуулинд тусгалаа олж байдаг. Иймээс хүний эрх, хуулийг дээдлэх ёсонд дэлхий нийтээрээ шилжин орж байгаа өнөө үед нийтлэг эрх ашгаа хамгаалах зорилгоор стратегийн өмгөөллийг хэрэглэх нь арга зүйн ихээхэн ач холбогдолтой.

Засгийн Газрын тогтолцоо, хуулийн орчин, шүүхийн бие даасан байдал, иргэдийн хууль ёсонд хандах хандлага зэрэг нь өмгөөллийг нөхцөлдүүлж байдаг гол хүчин зүйлүүд юм.

Нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөхөд шүүхийн тогтолцооны бие даасан байдал чухал үүрэгтэй. Үүнд:

- Шүүхийн тогтолцоо улс төрийн нөлөөллөөс ангид байгаа эсэх,

Хуулийг хэрэгжүүлэх, хүний эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд өмгөөллийг ашиглана. Үүний дүнд түүхийн туршид зүй бус, гадуурхагдсан харьцаанд өртөж байсан зарим нийгмийн бүлгүүдийг хуулийн хамгаалалд оруулж чадсан байна. Энэтхэг улсын Үндсэн хуульд иргэд тэгш эрхээр хангагдсан хэдий ч далит⁴ хүмүүс маш ихээр ялгаварлан гадуурхагддаг байв. Жишээлбэл, Борсад тосгоны иргэд Засгийн Газрын татсан усны хоолойн шугамыг тус тосгонд амьдардаг далит хүмүүст хүргүүлэхгүй гэсэн үүднээс нутгийн иргэд усны хоолойг тасалж орхисон байв. Энэ хэргийг Нийгмийн шудрага ёсны төв хэмээх байгууллага Борсадын далит хүмүүсийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тэд засгийн газар иргэдээ цэвэр усаар хангах үүрэгтэй гэсэн үндэслэлийг гаргаж тавьсан. Гужарат мужийн дээд шүүх энэ хэргийг Энэтхэг улсын Үндсэн хуулиар баталгаажуулан өгсөн хүний язгуур эрх болох амьд явах эрхийн асуудалтай холбон үзэж далит иргэдийн талд шийдвэр гаргасан байна. Шүүхээс тус тосгон дах цэвэр усны хоолойг уртасган засах ажлыг Засгийн газарт үүрэг болгосон байна.

- Хууль хэрэгжүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг шүүхээс хянах эрх мэдэл байгаа эсэх,
- Төрийн болон хувийн хэвшилтэй холбоотой асуудлаар шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх албан ёсны эрх мэдэл байгаа эсэх
- Шүүхийн тогтолцоо нь нэр хүнд, хүний нөөцийн хувьд мэргэжлийн чадавхитай эсэх.

Хуульчдад тулгардаг нэг бэрхшээлтэй асуудал нь хуульт ёсонд хандах олон нийтийн хандлага сөрөг байх явдал юм. Авилгалд автсан, хүч хэрэглэсэн үйл ажиллагаанд оролцдог шүүхийн тогтолцоонд олон жил байснаас иргэд эрх зүйн тогтолцоонд итгэх итгэл алдарч өргөдөл, гомдлоо гаргахдаа хойрго болдог. Иргэд шүүхээр шийдэгдэх боломжтой асуудлаараа хүртэл шүүхэд ханддаггүй. Тэд шүүхээр явах нь аюултай эсвэл үр дүнгүй гэж боддог. Үүнийг даван туулахад стратегийн өмгөөлөл туслах учиртай.

⁴ Далит гэдэг нь Энэтхэгийн хамгийн доод кастын нэр.

1.3. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ НЬ ЦОГЦ СТРАТЕГИЙН НЭГ ХЭСЭГ БОЛОХ НЬ

Шүүхийн танхимд ялалт байгуулах нь бахдан тэмдэглүүштэй үйл явдал мөн боловч тухайн шүүхийн шийдвэр дангаараа нийгэмд өөрчлөлт бий болгох боломжгүй юм. Шүүхийн шийдвэрийн дагуу нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа уг шалтгааныг шийдвэрлэх талтай хэдий ч нөгөө талаар уг шийдвэрт нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгод хүрэхэд саад болох зүйлс ч агуулагдаж байдаг. Зөв чиглэлд хийсэн бүрэн бус шүүхийн ялалт ч эцсийн дүндээ эерэг өөрчлөлтөнд хувь нэмрээ оруулдаг. Алсын хараатай байх нь нийтийн эрх ашгийг хамгаалахад амин чухал байдаг ч харин бүрэн амжилтанд хүрээгүй гээд ялалтаа зарлахгүй хойшлуулах нь эсрэг үр дүнд хүргэж, итгэл найдварыг сулруулахад хүргэж болзошгүй.

Үүнээс гадна, шүүхэд ялах нь цорын ганц чухал зорилт биш юм. Өмгөөллийн чиглэлээр хийж байгаа ажиллагаатай хамт өөр бусад олон үйл ажиллагаа хийгдэхгүй бол шүүхийн үйл явцаас гарсан эерэг үр дүн нийгмийн хувьд үр дүн муутай хоцорч болно. Иймд олон нийтийн кампанит ажил болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хяналт тавих, олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй. Жишээлбэл, АНУ-д Брауны гэж нэрлэгдсэн Цагаан, хар арьст хүүхдүүдийг сургуульд хамт сургадаг болгох тухай хэргийн шүүхийн шийдвэр нь нийгмийн өргөн хэмжээний өөрчлөлтийг дангаараа авчраагүй билээ. Үнэн хэрэгтээ, тэр шийдвэр нь хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан бөгөөд үл ялгаварлах төлөвлөгөөг анх хэрэгжүүлсэн сургуулиудад ч уг төлөвлөгөө нуран унаж байсан юм. Брауны хэргийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд маш их зүтгэл, чармайлт, хүч нөөц, тууштай байдал шаардагдсан бөгөөд энэ тэмцэл одоо ч үргэлжилж байна.

Зарим хэргүүдэд, нийгмийн тухайн асуудлыг бүрэн хэмжээнд шийдвэрлэх стратегийн бусад үйл ажиллагаатай уялдаагүйгээс шүүхийн танхимд болсон ялалтын үр нөлөө саарч, хүссэн үр дүнд хүрэхгүй явдал гарч байжээ. Тухайлбал, АНУ-д 1970-аад онд өмгөөлөгчид сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдийг шоронгийн дэглэмтэй ажиллаж байсан эмнэлгээс суллаж гаргах асуудлаар хууль зүйн талбарт амжилтууд гаргасан. Харамсалтай нь, тэдгээр

өвчтөнүүдэд зориулсан үйлчилгээний тохиромжтой хувилбар байхгүй байсан учраас олон өвчтөнүүд эмчилгээгүй хоцорч, тэдний бие муудах, заримдаа өвчин нь бүр ч даамжирч байжээ. Сэтгэцийн эмгэгийн эмнэлэгт байх шаардлагагүй байсан өвчтөнүүдийг суллахад нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг байгууллагууд гол үүрэгтэй ажилласан ч тэдгээр өвчтөнүүдэд зориулсан амьдрах байр, ажлын байрны хөтөлбөр, хямралын үеийн үйлчилгээ зэрэг тэдэнд тохирох үйлчилгээг нь бий болгох хэрэгцээ шаардлага нь хангагдаагүй юм.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэгч өмгөөлөгчдийн хувьд хамгийн их сэтгэл дундуур үлддэг зүйл нь өмгөөлөл амжилтанд хүрсэн ч байнга мөрөөр нь явж, хянаж байх шаардлага гардаг явдал юм. Чухам ингэж чадвал шүүхийн танхимд хүрсэн үр дүн нь урт хугацааны өөрчлөлтийг авчран, цаасан дээрхи ялалт төдий зүйл биш болдог.

Өмгөөлөл нь үнэ өртөг ихтэй, цогц үйл ажиллагаа байдаг бөгөөд заримдаа хүссэн зорилгодоо хүрэх нь хэцүү хүнд амаргүй боловч шүүхээр явах нь цорын ганц боломжит тактик ч байх талтай. Нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг ихэнх хуульчид үзэхдээ хэрвээ бодит өөрчлөлт хийж, өмнө хийсэн ололтоо хамгаалахын тулд өмгөөллөөс өөр хувилбар ихэнхдээ байдаггүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Ихэнх хэргүүдэд, нийгмийн сайн сайхны төлөө гүн гүнзгий өөрчлөлтөнд хүрэхийн төлөөх стратегийн цогцолбор үйл ажиллагааны зайлшгүй чухал хэсэг нь өмгөөллийн үйл ажиллагаа байдаг юм.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалахын төлөө ажилладаг байгууллагууд нь нийгмийн өөрчлөлтийн төлөө зүтгэлдээ маш олон төрлийн арга хэлбэрийг хэрэглэдэг.

Олон төрлийн үйл ажиллагааг багтаасан стратегийн өмгөөлөл бол тогтолцоог өөрчлөх хамгийн хүчтэй арга хэрэгслийн нэг юм. Нийгмийн өөрчлөлт авчрахад чиглэсэн үйл ажиллагаа бүр сайтар бодож боловсруулсан стратегийн нэг хэсэг байх ёстой. Хууль тогтоогч нарт нөлөөлөх, төрийн байгууллагуудтэй тулж ажиллах, олон нийтийн санаа бодлыг авах, хэвлэл мэдээлэлд хандах гэх зэрэг олон аргууд байна.

Бусад арга зам нь олон нийтийг хөдөлгөж, янз бүрийн бүлгүүд

үүний дотор төрийн байгууллагууд, хувь хүмүүсийн хамтын ажиллагааг өрнүүлдэг бол стратегийн өмгөөлөл нь нийгмийн өөрчлөлтийн төлөө зүтгэлд шүүх эрх мэдлийн хүчийг ашигладаг байна. Энэ нь ялангуяа шүүх бие даасан байр суурьтай, улс төрийн ашиг сонирхлын нөлөөнөөс харьцангуй ангид байдаг орнуудад илүү боломжтой байдаг. Мөн хараат бус байдал нь сул шүүх эрх мэдэлтэй улс оронд ч мөн стратегийн өмгөөлөл нь шинэчлэлтийн төлөө үйл ажиллагаанд шүүхийг хамруулж, мөн уг асуудлаар олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж чаддаг. Ийм жишиг хэрэг нь мөн шүүхийн тогтолцооны шинэчлэлийн хөдөлгөгч хүч болдог.

Зарим тохиолдолд, стратегийн өмгөөллийн ажиллагаа нь төр засгийн байгууллагаас тухайн асуудлаар тодорхой арга хэмжээ авах боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр, тухайн асуудлыг хариуцан хууль журмаа хэрэгжүүлэх ёстой боловч хайхрахгүй байсан байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжоо хэрэгжүүлэх хүчин зүйл болдог байна. Стратегийн өмгөөлөл нь Үндсэн хуулийн баталгааг хэрэгжүүлэх замаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн эрхийг сэргээх арга зам юм. Мөн өмгөөлөл нь эдгээр хүмүүсийг чадавхижуулах арга хэрэгсэл болдог.

Стратегийн өмгөөлөл нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах, тухайлбал, тухайн орон нутгийн ой мод, цэцэрлэг, талбайг сүйтгэхэд хүргэх барилга байгууламжийн төслүүд тухайлбал, хортой хог хаягдал зайлуулах талбай, орон сууцны хороолол барих зэрэг ажлууд хэрэгжихээс сэргийлэх арга болдог.

Нийтийн эрх ашгийг хамгаалсан стратегийн өмгөөллийн нэгэн хэрэг бол хар арьст хүмүүсийн ялгаварлахын эсрэг асуудлаар АНУ-д нилээд дээр үед хийгдсэн өмгөөллийн ажиллагаа юм. Өнгөт арьст хүмүүсийн аж байдлыг сайжруулах үндэсний холбооны хуульчид болон тус байгууллагын Хуулийн хамгааллын сан нь тус кампанит ажлыг 1930-аад онд эхэлсэн байна. АНУ-ын хамгийн ихээр олонд танигдсан ТББ-ын нэг болох тус холбоо нь АНУ-ын иргэний хөдөлгөөний тэргүүн эгнээнд олон жил явсан юм. Энэ холбооны хуульчдад, “улс төрийн” зөрчилдөөнтэй хэргүүдээр шүүгчдийн эсэргүүцэлтэй тулгарах, уламжлалт бус ял шийтгэлийг оногдуулах талаар туршлага дутагдах, статистикийн тоо баримт бүхий нотолгоог хүлээж авахаас татгалзах зэрэг одоогийн Төв болон Зүүн

Европын орнуудын нийтийн эрх ашгийг хамгаалагчдад тулгарч байгаа олон бэрхшээлүүд мөн адил тулгарч байв. Боловсролын салбарт байсан арьсны ялгаварлал нь Үндсэн хуультай харшилж байгааг шүүхээр тогтоолгохын тулд тус холбоо нь өөрсдийн хуульчдаа сургалтаар бэлтгэж, хүмүүсийг шүүхийн танхимд эрхээ хамгаалахад сургаж байжээ. 1938 онд цагаан арьстнуудад зориулсан хууль зүйн сургуулиудад хар арьстнуудыг элсүүлэх асуудлаар шүүх

АНУ-ын стратегийн өмгөөллийн жишээ: Боловсролын зөвлөлийн эсрэг Браун

1954 оноос өмнө АНУ-ын олон улсуудад дунд сургуулиуд нь арьсны өнгөөр ялгаварласан бүтэцтэй байсан ба хар арьст хүүхдүүд зөвхөн тэдэнд зориулсан сургуульд явдаг байв. Тэдгээр улсын хуульчид, нийтийн ашиг сонирхлыг хамгаалдаг байгууллагууд энэ байдлын эсрэг хэрэг үүсгэж хэд хэдэн улсын шүүхэд гомдол гаргасан байна. Тусдаа сургууль нь хар арьст хүүхдүүдийг нийгэмд доогуур байр суурьтай гэж ойлгоход хүргэж, тэдний хөгжлийг сааруулж, улам бүр ялгаварлалд хүргэж байна гэж тэд үзсэн. Тэдгээр хэргүүдийг 1954, 1955 онуудад шүүхээр нэгтгэн авч хэлэлцэж, АНУ-ын Дээд шүүх өмнө нь гаргасан “эрх тэгш гэхдээ тусдаа” гэдэг зарчмыг халж, сургуульд цагаан болон өнгөт арьстан хүүхдүүд хамт суралцах тухай шийдвэр гаргажээ.

Энэ хэргийн гол асуудал нь барилга байгууламж материаллаг нөхцлөөрөө адил ч арьсны өнгөөр тусгаарласан сургуулиуд нь цөөнхийн бүлгийн хүүхдүүдэд боловсролын тэгш боломжийг боогдуулж байна уу гэдэгт байгаа юм. Энэ асуултанд шүүхийн хариулт “боогдуулж байна” гэж гарсан байв. Шүүхийн энэ шийдвэр ихээхэн том амжилт байсан боловч уг шийдвэрийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болох нь удалгүй тодорхой болсон байна. Тусдаа суралцдаг байсан түүхэн цаг хугацаа болон цагаан арьстнуудын сөрөг хандлага зэрэгтэй холбоотойгоор сургуулиудыг нэгтгэх нь туйлын хэцүү байлаа. Тиймээс 1955 онд Брауны хэргээр хоёр дах шийдвэр гарч, “үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэх боломж нь түүнтэй санал нэг эсэхээс хамаарах ёсгүй” гэсэн байна. Ингээд Шүүхийн шийдвэрт зааснаар, уг асуудалд холбоотой сургуулиуд “бүхий л боломжийн хэрээр” шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байна.

хурлууд хийгдэж эхэлсэн бөгөөд энэ кампанит ажил Брауны гэж алдаршсан шүүхийн ажиллагаа 16 жилийн дараа болох хүртэлх замыг зассан юм.

Хэдийгээр энэ хэрэг нь маш өргөн хүрээний үр нөлөөтэй байсан ч шийдвэрийг хэрэгжүүлэх өөрчлөлтийн үйл явц урт удаан хугацаанд үргэлжилсэн. Стратегийн өмгөөллийн өмнөх сургамжаас суралцсан өнөөгийн хуульчид өөрсдийн үйл ажиллагаагаа төлөвлөж, тухайн хэргээ бүрэн хараандаа байлгахыг чармайх болсон.

Стратегийн өмгөөллийн гол хэсэг нь кампанит ажил өрнүүлэх явдал юм. Энэ нь нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн нэг чухал хэсэг юм. Энэ үйл ажиллагааг зохион байгуулахдаа эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг бий болгох зорилготой кампанит ажлыг системтэй өрнүүлэх, олон нийт болон хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах арга замыг зөв сонгох хэрэгтэй байна. Жишээлбэл, сэтгүүлчээр дамжуулан нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хүрээнд тулгарч буй асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж болно.

1.4. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Нийтийн эрх ашгийг хуулиар хамгаалах гэсэн нэр томъёо нь 1960-аад оноос АНУ-д өрнөсөн олон нийтийн хөдөлгөөнтэй холбоотойгоор өргөн дэлгэрсэн юм. Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйлс нь олон зүтгэлтнүүдийн үзэл санаа, үйл хэргээс эхтэй. Тухайлбал Луйс Брэндэйсийн үйл хэргийг энд дурьдаж болох бөгөөд тэрээр эрх зүйн өмгөөллийн хүрээнд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалж, амжилтанд хүрч улмаар АНУ-ын Дээд шүүхийн гишүүнээр томилогдон ажиллаж байжээ. Өмгөөллийн үйл ажиллагаагаа ид явуулж байхдаа 1950 онд тэрбээр “өнөөгийн хуульчид нь томоохон корпорацуудын “дагуул” болон хувирсан бөгөөд тэд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хуульч хүний мэргэжлийн ёс зүйгээ умартсан байна” хэмээн шүүмжилж байв. 1960-1970 онуудад Америкийн хууль зүйн олон их дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд энэ чиглэлийг идэвхтэй сонгон суралцаж, тухайн үеийн нийгмийн тулгамдсан асуудлуудад нөлөөлж, түүнийг

шийдвэрлэхийг чармайх болсон байна. Тэд Брандэйсийн хэлснээр “People’s lawyers” буюу олон нийтийн хуульч хэмээн өөрсдийгөө нэрлэн, корпорацуудын үйлчлэгч, дагуул байхаас татгалзахыг хичээх болжээ. Гэхдээ нийтийн эрх ашгийг хамгаалагч хуульчид нь Брандэйсийн “People’s lawyers” тай харьцуулахад арай өргөн хүрээтэй ажилладаг ба тэдний үйл ажиллагаа зөвхөн ядуусын эрх ашгийг хамгаалахаар хязгаарлаагүй байна. Тухайлбал, байгаль орчны нөлөөлөл нь зөвхөн ядуусын эрх ашгийг хамгаалаад зогсохгүй нийгмийн дунд болон дээд хэсгийнхний ч эрх ашгийг илэрхийлдэг.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйлс энэ зууны эхэн үеийн Луйс Брэндейс зэрэг сэтгэгчдээс улбаалан, 1960 оны зүтгэлтнүүдийн үйл хэргээр үргэлжлэн, орчин үеийн европын сэтгэгчид болох Юрген Хабермас, Вацлех Гавел нарын үзэл санаагаар баяжин дэлхий нийтээр хөгжиж байна.

АНУ-ын Дээд шүүхийн гишүүн Торогуд Маршалл 1975 онд Америкийн хуульчдын холбооны хурлын нээлт дээр: “Тэд өнөөгийн шүүхийн үйл ажиллагааг сайжруулан шийдвэр гаргагчдад илүү өргөн хүрээний мэдээллийг хүргэж чаджээ. Тэд шүүхийн тогтолцооны удирдлага, шүүгчдэд тэдний гаргасан шийдвэр, эрх нь зөрчигдсөн цөөнхийн бүлгийн хувь заяанд хэрхэн нөлөөлж болохыг ойлгуулж чадсан юм. Ийнхүү тэд бүх нийтээр шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүхэд хандах боломж иргэдэд тэгш байх эрмэлзэл загвар руу биднийг ойртуулах хуулийн хаалгыг нээж өгсөн юм.” хэмээн нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалагчдын үйл хэргийг дүгнэжээ⁵.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах ямар нэгэн тусгайлсан эрх зүйн акт, баримт бичиг байдаггүй, энэ үйл хэрэг нь тодорхой нэгэн салбар эрх зүйн чиглэл ч биш юм. Харин энэ ойлголт нь нийтийн эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэх хүрээнд ажиллаж байгаа хуульчдад л хамаатай юм. Эдгээр хуульчид нь нийгэмд төдийлөн сайн илэрхийлэгдэж чадахгүй байгаа бүлгийн ашиг сонирхлыг хамгаалан ажилладаг учраас нийгмийн ядуу

⁵ Эдвин Рокиш, Кира Вучко, Вэссела Терзиева нарын Pursuing the Public Interest: A Handbook for Legal Professionals and Activists нарын номноос ишлэв. (New York: Public Interest Law Initiative 2001), p 23

давхаргатай холбогдох нь элбэг байдаг. Иймээс энэ нэр томъёонд өнөөдөр хүний эрх, эрх чөлөө, эмэгтэйчүүдийн эрх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах гэх мэт олон зорилтуудыг өмнөө тавьсан хуульчдын үйл ажиллагааны өргөн хүрээ хамаарагдаж байна.

АНУ-д нийтийн эрх ашгийг хамгаалан ажилладаг байгууллагууд нь “нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах” буюу тухайн нийгмийн бүлгийн зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр төлөвшин бүрджээ. Өнөөдөр АНУ-д нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах гэдэг ойлголт институцийн түвшинд хүртэл хөгжсөн байна. Тус улсад төрийн бус байгууллагууд хэрэглэгчдийн эрх, байгаль орчин, хүний эрхтэй холбоотой асуудлыг хуулийн хүрээнд өмгөөлөн ажиллаж тэднийг нийтийн эрх ашгийг хамгаалагч байгууллагууд хэмээн нэрлэж байна. Хууль зүйн их дээд сургуулиудад эрх зүйн клиник сургалтын хөтөлбөрүүд хэрэгжиж ядуус, эмэгтэйчүүд, ялгаварлан гадуурхалт, байгаль орчин, Үндсэн хуулиар баталгаажсан эрх зэрэг салбаруудад хуулийн нарийн төвөгтэй асуудлуудаар дадлага хийж мэдлэг чадвар хуримтлуулах боломжийг оюутнуудад олгож байна. Хэд хэдэн сургуулийн хуулийн факультетэд “Нийтийн ашиг сонирхлийг хамгаалах хууль” хэмээх төвийг байгуулан ажиллуулж цаашид энэ чиглэлээр ажиллах сонирхолтой оюутнуудад зөвлөгөө өгдөг байна. Мөн тус улсад хуулийн товчоод нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үнэ төлбөргүй үйл ажиллагаа буюу pro bono явуулж нэгэнт хэвшжээ.

1980-1990 онуудад “нийтийн эрх ашиг” хэмээх уг ойлголт бусад улсуудад ч хүчтэй яригдаж, түүнийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн байна. Жишээлбэл, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад арьсны өнгөөр ялгаварлан үзэх апартейд дэглэмийн эсрэг тэмцлийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа эрчимтэй явагдсан. Мөн Англи, Энэтхэг, Бангладеш, Филиппин, Австрали, Чили, Аргентин зэрэг улс орнуудад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа эрчимтэй хөгжсөн байна.

Постсоциалист орнуудад нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагаа хэрхэн явагддаг байсныг ерөнхийд нь дараах байдлаар дүрсэлж болно. Тэдгээр орнуудад энэ ойлголт нь Юрген Хабермас зэрэг сэтгэгчдийн “нийгмийн салбар”, Вацлав

Гавелийн “иргэний нийгэм” үзэл санааны хөгжлийг агуулсан улс төрийн өргөн хүрээний өөрчлөлтөөр нэвтэрсэн. Социалист эрх зүйн онол, хууль зүйн системд нийтийн ашиг сонирхол хэмээх ойлголт танил биш гэж хэлж болно. Энэ онолоор прокурор нь ард түмний эрх ашгийг иргэний болон эрүүгийн санкцуудыг хэрэглэн хамгаалах үндсэн үүрэгтэй юм. Иймээс нийтийн ашиг сонирхлыг хамгаалах социалист болон либерал нэр томъёоны хооронд их ялгаа бий. Хабермасын үзэж байсанчлан ашиг сонирхлоо хамгаалах олон нийтийн идэвхитэй үйл ажиллагаа, альтернатив дуу хоолой зэрэг нь социалист эрх зүйн тогтолцоонд байдаггүй. Социалист эрх зүйн онолоор ард түмний эрх ашиг бол нийгмийн дээд эрх ашиг бөгөөд иймээс улс төрийн тогтолцооны дээд түвшин болох хатуу хяналттай төрийн тогтолцоонд прокурорын байгууллагаар хамгаалагдаж байдаг байлаа. Тийм ч учраас социалист орнуудад “ард түмний эрх ашиг” гэсэн нэр томъёо нь “төрийн эрх ашиг” хэмээх нэр томъёотой ижилхэн хэмээн тооцогдож байсан бөгөөд социалист системийн задралын дараагаар энэ хоёр ойлголтыг ялгаатай хэмээн үзэж байна⁶.

1.5. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ЗАРИМ ТУРШЛАГУУД⁷

Зарим улс орнуудын нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл хийх, түүний төлөө өрнөсөн үйл ажиллагааны туршлагыг доор толилуулж байна.

Өмнөд Америкийн өмнөд эрэг, Андын бүсийн нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах туршлага

Андын орнуудад ардчилал эхэлсэнээр энэ бүс нутгийн ажиллаж байсан хүний эрхийн байгууллагуудын стратеги нь дарангуйллыг эсэргүүцэх хэлбэрээс шинээр өрнөж байсан ардчиллын процесст хүний эрх хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх түүнчлэн хүний

⁶ Ийм учраас энэ гарын авлагыг зохиогчид нь public interest хэмээн англи үгийг “ард түмний эрх ашиг” гэж хэлэлгүйгээр “нийтийн эрх ашиг” хэмээн орчуулан буулгаж байгаа болно.

⁷ “Many roads to justice” The Ford Foundation, 2000 номыг ашиглав.

эрхийн баталгааг хангахад чиглэн өөрчлөгдсөн байна. Тодруулбал, үйлдэгдэж байгаа хүний эрхийн зөрчлийг хууль, шүүхийг ашиглан шийдэхэд шинэ стратегийн зорилго оршиж байв. Энэ шинэ стратеги нь гол төлөв цагдаагийн хүчирхийлэл, хүйсийн ялгаварлал, хууль, дүрмийн зөрчил, олон нийтийн мэдээлэл авах зэрэг эрхийг хэрэгжүүлэхэд олон улсын стандартыг хэвшүүлэн тогтооход чиглэж байв.

Энэ бүс нутагт ажилладаг хүний эрхийн төрийн бус байгууллагууд, хүний эрхийн идэвхтэн зүтгэлтнүүд засаг төрийн байгууллагатай хариуцлага тооцоход хуулийг хамгийн чухал хэрэгсэл гэж үзэх хандлага улам бүр нэмэгдсэн. Сүүлийн жилүүдэд энэ бүс нутгийн орнуудад хийгдсэн эрх зүйн шинэчлэлтээр олон шинэ хууль батлагдаж, шинэ Үндсэн хуулиар олгогдсон заалт болох гуравдагч тал шүүхэд нэхэмжлэл гаргаж болохыг хүлээн зөвшөөрч омбудсманы газрыг байгуулсан байна. 1991 онд Колумб улсад шинэ Үндсэн хууль батлагдаж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрчээ. Үндсэн хуулийн дагуу нийгмийн тодорхой бүлэг ийм үйл ажиллагаа явуулах боломжийг үндэслэсэн байна. 1993 оны Перу улсын Үндсэн хуулиар хүний эрхийг баталгаажуулаад зогсохгүй төрийн байгууллагаас мэдээлэл шаардах, эрүүл орчинд амьдрах, хүн бүр гарал үүслийнхээ дагуу ёс заншлаа даган мөрдөж амьдрах эрхийг нь шинээр баталгаажуулан уг эрх нь зөрчигдсөн тохиолдолд өөрөө шүүхэд хандаж нэхэмжлэл гаргахаас гадна мөн төрийн бус байгууллага болон омбудсмен төлөөлөн гаргаж болох ажээ.

Хэдийгээр Үндсэн хуулийн ийнхүү шинээр бий болгосон заалтууд нь хууль, нийгмийг өөрчлөх шинэ боломжийг бий болгож байсан боловч түүнийг хэрэгжүүлэн дэвшил гаргахад хуулийн болоод бүтцийн тодорхой хүчин зүйлүүд саад болсоор байсан. Үүнээс хамгийн гол саад нь шүүхийн тогтолцоонд оршиж байсан хууль бус үйлдлүүд байв. Жишээ нь, Аргентины хүний эрхийн байгууллагын үзэж байснаар энэ оронд шүүхээр шийдвэрлэгдсэн тэргүүлэх ач холбогдолтой хэрэг АНУ-ын шүүхийнхтэй адил нөлөө үзүүлж чадахгүй байв. Учир нь авилгалд автагдсан эсхүл анхаарал хайхрамжгүй хандлагаасаа болж шүүгчид нь хамгийн төсөөлж боломгүй шийдвэрийг гаргадаг байв. Перугийн байгаль орчны асуудлаар ажилладаг хуульчдын үзэж байснаар авилгалд автсан

шүүгчид болон шүүхийн хараат бус байдлыг алдагдуулдаг улс төр, засаг захиргааны ажилтнуудын балгаас болж шүүхийн шийдвэр гаргах явц нь ихээхэн хүндрэлтэй байжээ. Тийм ч учраас энэ бус нутгийн хуульчид зөвхөн шүүхэд найддаггүй байна. Тэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах, засаг төрийн байгууллагад мэдээлэл, хүсэлт илгээх, мөн тухайн оронд хөрөнгө оруулсан гадаадын корпорацуудын захирлуудын зөвлөлийг лоббидох зэрэг үйл ажиллагаа явуулж байв.

Энэ бус нутагт нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааг эрхэлж байгаа хүмүүс хуучинсаг шүүхийн тогтолцооноос үүдэлтэй дээрх бэрхшээлийг даван туулахад үндсэн хоёр чиглэлийн үйл ажиллагааг явуулах хэрэгтэй гэдэгт эргэлздэггүй байв. Үүнд: нэгдүгээрт, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хуулийн үзэл санаа болон шүүхэд оруулах гэж байгаа тодорхой асуудлаар шүүгчдийг сургах, хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүмүүст хүрч, олон нийтийг дайчлах замаар өргөн хүрээнд сурталчлан засаг захиргааны байгууллагын хариуцлагыг өндөржүүлэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад тус дэм болж амжилтанд хүрэх байв. Тийм ч учраас олон нийтийг зохион байгуулах, тэдэнд сурталчлан таниулах, сургах, захиргааны болоод хувийн байгууллагуудтай хариуцлага тооцдог болгох, нийтийн эрх ашгийг хамгаалах өмгөөлөл хийх зэрэг үйл ажилагааг явуулсан байжээ. Тэд одоо ч эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийн эрх болон хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг үргэлжлүүлсээр байна. Тэд мөн нийгэмд шинэ өөрчлөлтийг авчрахын тулд үргэлж хамтран ажиллаж байна. Жишээ нь, Диего Порталесийн Их сургууль нь Аргентин, Чили, Перугийн их сургуулиуд дээр ажилладаг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн клиникуудын консорциумын зохицуулагчаар ажилладаг байна.

Хүний эрхийн төлөө хөдөлгөөн нь эдгээр оронд хуулийн болон нийгмийн өөрчлөлтийг хийж болохыг харуулсан юм. 1970, 1980-аад оны хүний эрхийн төлөө хийсэн тэмцэл болон харьцангуй сүүлд гарч ирсэн нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах хөдөлгөөн нь харилцан бие биеэ нөхцөлдүүлэн бэхжүүлж, улам эрчимтэй хөгжих боломж олгосон байна. Жишээ нь Диего Порталесийн хууль зүйн сургуулийн багш нар өмнө нь хүний

эрхийн төлөө хөдөлгөөнд идэвхтэй оролцогч байсан бол хүний эрхийг хамгаалахад хуулийг ашиглах аргыг маш өргөн хүрээний асуудлуудад хэрэглэн ажиллах болжээ. Тэд болон төрийн бус байгууллагууд эмзэг бүлгийн эсрэг гадуурхалыг зогсоох, олон нийтийн мэдээлэл авах эрх болон бусад эрхийг баталгаажуулахад жишиг болох хэргийг өмгөөлөн ажиллах болсон байна.

Эрх зүйн үйлчилгээг олон нийтэд хүргэхэд шүүхийн бус арга замыг ч хэрэглэж болдог байна. Ийм үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд нь өөрсдөө өсч хүчирхэг болоод зогсохгүй олон нийтэд асуудлаа шударгаар шийдүүлэх, хуулиар олгогдсон эрхээ хамтаараа эдлэх боломжийг нэмэгдүүлдэг байна. Ийм үйл ажиллагаа явуулдаг байгууллагын нэг болох Колумбийн Олон Нийтийн Сан уугуул иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний соёлын өв уламжлал, төрсөн нутагтаа амьдрах эрхийг нь хүндлэн хамгаалахыг зорьж ажилладаг ажээ. Мөн 1980-аад оны дундуураас тэр үеийн хүний эрхийн хөдөлгөөнөөс гадуур, тэр үеийн эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг байгуулагуудаас эрс өөр асуудлаар ажилладаг байгууллага, багш нар, хуульчид бий болсон. Үүний жишээ нь 1986 онд Перу улсын залуу хуульчдын санаачлагаар байгуулагдсан Перугийн Байгаль орчны хуулийн нийгэмлэг юм. Энэ байгууллагын зорилго нь нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөх, сургалт, олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх замаар хуулийг байгаль орчныг хамгаалах хэрэглүүр болгон ашиглахад оршиж байв. Ийнхүү Аргентин, Чили, Колумб улсад ч ялгаагүй олон тооны хуульчид нийтийн эрх ашгийг хамгаалахад хуулийг ашиглах арга замыг эрэлхийлж эхэлсэн.

Энэ бүс нутагт эхэлсэн нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хөдөлгөөн нь нийгэмд шударга ёсыг тогтоох, хүмүүсийн амьдралыг сайжруулах арга замыг эрж хайсан судалгаа хэрхэн амьдралд бодит нөлөө үзүүлж байгааг харуулсан хүчтэй үзэл санаан дээр тулгуурлан хөгжсөн. Колумбын нэрт хуульч Герман Сармиенто аль 19-р зууны иргэний хуульд олон нийтийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрдөг байсан ба хэрэв зам, талбай, гол, нуур зэрэг нийтийн хэрэглээний эд зүйлд хувь хүний болон төрийн үйл ажиллагаанаас болж гэм хор учирвал иргэн шүүхэд хандаж болох байсан тухай 1988 онд өөрийн гаргасан номондоо бичжээ. Үүнийг уншин урам орсон бүлэг хуульчид Нийтийн Эрх

Ашгийг Хамгаалах Сан гэдэг нэртэй ТББ-ыг байгуулжээ. Хожим нь энэ байгууллага байгаль орчны асуудлаар хийсэн өмгөөллийн үйл ажиллагаагаараа олны анхаарлыг татжээ. Учир нь 1989 онд хотын шинэчлэлтийн асуудлаар чухал хууль батлагдсан ба энэ хуулиар нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, засаг захиргааны үйл ажиллагаа шударга байх тал дээр иргэд нэхэмжлэл гаргах эрхтэй болсонтой холбоотой гэж энэ байгууллагын захирал, өмгөөлөгч Эрнесто Микелсен тайлбарласан байдаг.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалахад энэ бүс нутагт үндсэн дөрвөн төрлийн стратеги хэрэглэсэн. Үүнд: нөлөөллийн өмгөөлөл хийх; нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллах хуульчдын хамт олныг бүрдүүлэх, чадавхижуулах; хууль зүйн сургуулийн оюутнуудыг энэ чиглэл рүү бэлтгэх; олон нийтэд болон шийдвэр гаргах хүмүүст нөлөөлөх зэрэг байв. Гэхдээ аль ч стратегийг хэрэглэхэд олон нийтийн оролцоог хангах нь чухал байдаг гэж энэ бүсэд ажилладаг байгууллагууд үзжээ.

Жишээлбэл, “Аргентины Иргэдийн Хүч” байгууллага төрийн албан тушаалтныг иргэдийн өмнө хариуцлагатай байх явдлыг хянаж хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангаж тэдний туслалцаатайгаар олон нийтэд нөлөө ихтэй хэргийг сонгон авдаг байна. Эхний үед иргэд тодорхой хэрэг авчрах чадваргүй байдаг боловч нийгмийн сектор бүрт байгаа тэгш бус байдал, ялгаварлан гадуурхлын тухай өргөн мэдээлэл өгдөг байна. Улмаар иргэдийн мэдлэг, мэдээлэл сайжрах тусам олон хэрэг авчирдаг болжээ. Ийм хэргийн нэг болох Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах хуулийг хэрэгжүүлэх нэхэмжлэлийг Иргэдийн Хүч, Иргэний эрхийн холбоо хоёр 1996 онд иргэдийг төлөөлөн хамтран гаргасан нь амжилтанд хүрч Буэнос Айрес хотын шүүхүүдэд тэргэнцэртэй хүн өөрөө орох боломжтой болсон байна.

Иргэдийн Хүч байгууллага мөн бусад ТББ-тай хамтран нийтийн эрх ашгийг хамгаалахад хууль ашиглах асуудлаар сургалт, семинар зохион байгуулан байгаль орчин, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран эрхээ хамгаалахын тулд нийтийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа хийх талаар хоёр ч гарын авлага боловсруулжээ. Оюутнууд, олон нийтийн идэвхтэн зүтгэлтнүүдийг мөн дээрх сургалтанд хамруулжээ.

Нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөх нь иргэдийн хүчтэй тэмцэл өрнөх нөхцөл болж болдог байна. Байгаль Орчны Хуулийн төлөө Перугийн Холбоо нь Лимад тусгай хамгаалалтанд байдаг цорын ганц газар болох Пантанос де Виллад Чилийн нэг компани том үйлдвэр барихыг зогсооход эрх зүйн туслалцаа үзүүлэн олон улсын байгууллагатай холбож өгсөн. Энэ тохиолдолд хуулийн өмгөөлөл нь оршин суугчдын томоохон улс төрийн тэмцэл бож өрнөсөн.

Олон нийтийн өргөн дэмжлэг авах мөн нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд саад учруулах сөрөг үр дагавар гаргахгүйн тулд эхний үед сонгосон хэргүүд харьцангуй хурц зөрчил агуулаагүй асуудлуудад чиглэсэн байв. Тухайлбал эхний хэдэн хэрэг нь ялгаварлан гадуурхах үзэгдлийн эсрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэд шүүхэд орж чаддаг болох зэрэг олон түмэн, хэвлэл мэдээллээс өргөн дэмжлэг авах хэрэг байсан.

Бусад хэрэг нь эрх мэдлийн гол цөм рүү онилсон байсан. Колумбын Олон нийтийн Сан /FUNDEPUBLICO/ албан тушаалтны авилгалын хэрэг дээр ажиллаж эхэлсэн. Энэ нь, тухайлбал, засгийн газар авилгалд автан олон түмэнд хүнд хохирол учруулбал нийтийн ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрдөг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр дээр үндэслэдэг байна. Энэ байгууллагаас амжилттай ажиллан ялалт байгуулсан хэргүүдэд улсын уул уурхайн эрх ашгийг хохироосон хувьчлалын асуудал орж байв.

Энэ үйл ажиллагаанд орсон хуульчидад тохиолдож байсан түгээмэл бэрхшээл нь шүүх хуралдааны тов удаашрах, шүүхийн үл тоомсорлох байдал, мөн шүүхийн тогтолцооны авилга байлаа. Түүнээс гадна нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалж байгаа өмгөөлөгчид хуулийн мэргэжилтнүүдийн дунд цөөн байсан. Тэдний үнэлгээ нь хэр зэрэг чухал хэрэг сонгож, хэвлэл мэдээллийн анхаарлыг татан, эмзэг бүлгийн хүмүүст шударга үнэнд хүрэхэд тусалж чадаж байна гэдгээр хэмжигдэж байв.

Хэдийгээр дээр дурдсан бэрхшээл хаа саагүй тулгарч байсан боловч шүүхийн үйл ажиллагаанд нааштай өөрчлөлтүүд гарах болсон. Жишээ нь Аргентины CELS захиргааны шүүхээс дотоод хэргийн сайд руу Буэнос Айросын Холбооны Цагдаагийн Газарт

баривчлагдаад байгаа хүмүүсийн тоог мэдэгдэх тушаал гаргахыг хүссэн. Тушаал нь гарч цагдаагийн байгууллага шаардсан мэдээллийг өгсөн байна. Өөр хэрэг дээр CELS-ийн хуульчид орон нутгийн засаг захиргааг үүргээ биелүүлэн гурван сая хүн амд аюул учруулж болзошгүй өвчний эсрэг бүх нийтийг вакцинжуулахыг шаардан нэхэмжилсэн. Гэтэл Эрүүл мэндийн яамнаас вакцин үйлдвэрлэдэг болно гэдгийг зарлангуут анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Иймээс CELS давж заалдан вакцин үйлдвэрлэх үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн байгууллагуудыг үр дүнгийн талаар шүүхэд мэдээлж байх захирамж гаргуулсан байна.

Нийтийн эрх ашгийг хуулиар хамгаалах үйлсэд оролцож байгаа хуульчид тэдний үйл ажиллагааны дүнд шүүхийн тогтолцоо илүү боловсронгуй болно гэж найддаг. Өмгөөллийг амжилтанд хүргэхийн тулд шүүгчдийг нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үзэл баримтлал болон эрүүл аюулгүй орчин, хэрэглэгчдийн эрх ашиг, хүний нийгэм эдийн засгийн эрх зэрэг нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар бусад оронд гаргасан шүүхийн шийдвэрүүдтэй танилцуулах хэрэгтэй юм.

Энэ бүс нутгийн орнуудын туршлагаас харахад нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хуульчдын хамт олныг бүрдүүлэхэд эхний шатанд үндэсний семинарууд дараа нь бүсийн хэмжээнд бага хурал зохион байгуулж мэдээлэл, туршлагаа хуваалцан энэ чиглэлээр ажиллах сонирхолтой хуульчдын сүлжээ байгуулсан байна. Эдгээр семинар, хурал нь 1995 онд зохион байгуулагджээ. Үүгээр хууль зүйн сургуулийг татан оролцуулах алхамыг тодорхойлжээ. Үүний дүнд 1996 оны 12 сард нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллах хууль зүйн сургуулиудыг клиникүүдийн сүлжээ байгуулагджээ. Эдгээр клиник нь стратегийн өмгөөлөл хийдэг, үндэсний болон бүсийн хэмжээнд хоорондоо оюутан, багш солилцдог мөн харьцуулсан судалгааг хамтарч хийдэг байв. Ийнхүү хамтарч ажиллах нь тэдэнд бүсийн хэмжээнд өөрсдийн хийж байгаа болон хийсэн ажлыг эргэн харж дүгнэх, үндэсний хэмжээнд хамтарч ажилласнаар хэрэг сонгох нэгдсэн шалгууртай болох мөн шаардлагатай тохиолдолд хүний эрхийн олон улсын баримт бичгийг ашигладаг болоход анхаардаг болгосон. Үүний зэрэгцээ энэ үйл ажиллагаанд оролцсон ТББ,

хууль зүйн сургуулиуд төрийн албан хаагчид болон өмгөөлөгчидтэй холбоо харилцаагаа өргөжүүлсэн. Жишээ нь Перуд ажилладаг эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалдаг ТББ /DEMUS/ Перугийн Дотоод яамтай үр дүнтэй хамтын ажиллагаа хөгжүүлж Лимагийн цагдаагийн байгууллагад зориулан сургалтууд хийсэн. Чилид Тимукогийн Католик их сургуулийн эрх зүйн клиник хүйсээр болон арьс өнгөөр ялгаварласан, хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчсөн хэргээр ажиллахын тулд эмэгтэйчүүд, хэрэглэгчид, уугуул иргэдийн асуудлаар ажилладаг төрийн байгууллагуудтай гэрээ байгуулсан. Хувиараа ажилладаг өмгөөлөгчдийг татан оруулах нь чухал алхам байсан. Жишээ нь, 1997 оны 8 сард Перу улсын Лима хотын Католик их сургуулийн эрх зүйн клиник Байгаль орчны хуулийн нийгэмлэг болон үнэ төлбөргүй үйлчилгээгээрээ нэрд гарсан хуулийн фирмтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан. Мөн 1997 оны 7 сард Чилийн Диего Порталесийн эрх зүйн клиник өмгөөлөгчидтэй уулзалт зохион байгуулан өөрсдийн ажлын тухай мэдээлсэн. Өмгөөлөгчид хэрэг сонгоход зөвлөгөө өгөх саналаа хэлж, шүүхийн процессод хамтарч ажиллаж болох талаар ярилцан хууль зүйн сургуулиас шүүгчдэд зориулан нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах тухай сургалт зохион байгуулахыг санал болгожээ. Мөн Чилийн FORJA бас нэгэн найдлага төрүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг Чилийн Өмгөөлөгчдийн холбоо, Ядуурлыг бууруулах үндэсний сантай байгуулж нийтийн эрх ашгийг хөндсөн хэргүүдэд хувийн өмгөөлөгчдийг оролцуулах болсон байна. Ийнхүү хамтран ажиллах нь хуулийг хэрэгжүүлж шударга ёс тогтооход чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагаанд хууль зүйн сургуулийн оюутнуудыг бэлтгэхдээ хууль зүйн сургуулиуд дээр клиник байгуулан тэнд нийгэмд нөлөө үзүүлэхүйц хэрэг дээр ТББ-тай хамтран ажиллах сонирхол бүхий оюутнуудыг татан оролцуулдаг байна. Ийнхүү клиник сургалтанд хамрагдан ТББ-тай ажиллаж байсан оюутнуудаас нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааг үргэлжлүүлэх, ядуу, эмзэг бүлгийн асуудлыг ойлгодог эрх зүйч мэргэжилтэн бэлтгэгддэг ажээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа ихэнх материал нь аливаа асуудлын хамгийн хурц хэсгийг гарган дуулиан

болгоход илүү анхаарч, олон нийтийг сургах гол агуулга алдагдах нь олонтой байдаг. Үүнээс зайлсхийхийн тулд Иргэдийн Хүч байгууллага хоёр арга хэрэглэсэн байна. Нэгдүгээрт, янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тухайн асуудлаарх өөрийн үзэл баримтлалыг өргөн түгээх. Хоёрдугаарт, сэтгүүлчдэд зориулсан нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах ерөнхий үзэл санаа болон тухайн асуудлаар хийж байгаа өмгөөлөл болон үүнийг хийснээр иргэд өөрийн эрхийг шууд болон шууд бусаар хамгаалдаг болох, ардчиллыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой гэдгийг ойлгуулсан сургалт семинарыг зохион байгуулдаг байна.

Ийнхүү дээр өгүүлснээр 1990 оны сүүлч гэхэд улам олон хуульчид болон байгууллагууд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалж нийгэмд шударга өөрчлөлт хийх зорилгоор нийтэд нөлөөлөх, сургах, олон нийтийг зохион байгуулах, өмгөөлөх, бодлого боловсруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон. Үүний дүнд хүний эрхийн асуудлаар янз бүрийн хэлэлцүүлэг өргөн зохион байгуулагддаг болж, эдгээр хэлэлцүүлэгт хууль зүйн сургуулийн эрдэмтэд, оюутнууд, ТББ-ууд мөн эрх зүйн чиглэлээрх мэргэжлийн байгууллагууд оролцох болсон. Хамгийн гол нь эдгээр үйл ажиллагаа нь эрх нь хөндөгдсөн ард иргэдийн амьдралд бодитой мэдэгдэхүйц өөрчлөлт авчирсан.

Зүүн Европын шилжилтийн нийгэмд нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааны туршлага

1995 онд Зүүн Европт коммунист дэглэм нурж, ардчилсан дэглэм тогтсон. Хэдийгээр шинээр тогтсон залуу ардчилал хөгжин дэвшиж эхэлсэн боловч өнгөрсөн нийгмээс ард түмний дунд үлдсэн хууль, шүүхэд үл итгэх байдал бат бөх хэвээр байв. Учир нь өмнөх нийгэмд хууль нь гол төлөв төрийн хэрэгсэл болж, төрд үйлчилж байсан болохоос иргэд гомдлоо хуулиар барагдуулах нь ховор байв. Зөвхөн эрх мэдэлтэй хүмүүс эрх зүйн туслалцаа авахаас жирийн хүмүүс шүүхээс аль болохоор зайлсхийх хандлагатай байв. Ийм нөхцөлд эдгээр орнуудад ардчилсан өөрчлөлтийн хамт хийгдэж байсан эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрүүд нь хуулийг хэрэгжүүлэх механизмыг өөрчлөхгүйгээр, шударга шүүхээр шүүлгэх боломжийг ард олонд хүртээлтэй болгохгүйгээр үр дүнд хүрэхгүй байсан. Ингэхгүй аваас ард түмний хуульд үл итгэх хандлагыг

улам лавшруулах болно гэсэн болгоомжлолд хүргэж байв. Хуулиас зайлсхийх нь нэр төрийн хэрэг мэт үнэлэмж нийгэмд нь хэвшээд байхад хуулийг дээдлэн хүндэлж даган биелүүлдэг болох хандлагыг төлөвшүүлэх нь хүндхэн сорилт байсан гэж энэ бүс нутагт эрх зүйн клиник сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан Вашингтоны Католик Их Сургуулийн профессор Лийх Вортхам дурсан өгүүлсэн байдаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үндэстний асуудал, үндэстний цөөнхийн хүний эрхийн асуудал үүнд ялангуяа цыган иргэдийг ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх нь энэ бүс нутгийн тулгамдсан зорилт болж байв. Энэ бүс нутагт өргөн тархсан бусад асуудал нь гэр бүлийн хүчирхийлэл, цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчил, шүүхийн шуурхай бус үйл ажиллагаатай холбоотой. Эдгээр асуудал нь энэ орнуудад бүгдэд нь байсан бөгөөд харин хэр зэрэг гүнзгийрсэн байна гэдгээрээ ялгаатай байв.

Унгарын Иргэний Эрх Чөлөөний Холбоо /ИЭЧХ/ нь өвчтөний эрх, ялангуяа хувийн нууцыг хамгаалах эрх, мэдээлэл авах эрхийн чиглэлээр иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлж байв. Энэ байгууллага нөлөөлөх ач холбогдолтой хэргийг шүүхээр шийдүүлэх, хувь хүмүүст эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, олон нийт болон бодлого боловсруулагчдыг сургах чиглэлээр ажиллаж байв. Энэ байгууллага 1997 онд сэтгэцийн эмгэгтэй өвчтөнг цахилгаан гүйдлээр эмчлэн, гэр орныхонтой нь уулзуулахгүй байсан эмнэлгийг шүүхэд өгчээ. Тэр үед сэтгэцийн эмгэгтэй өвчтөнг эмчлэх талаар хуульчлан тогтоосон хэм хэмжээ байсангүй. Тиймээс энэ эмнэлгийн эмчилгээг хүний эрхийг зөрчсөн хэмээн зарлаж, хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан байна. Шүүх ИЭЧХ-ноос 1989 оны шинэ Үндсэн хуулийн хүний эрхийн заалт болон Иргэний хуулийн заалтыг үндэслэн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авчээ. Энэ хэрэг нь Унгарт хүний эрхийн шинэ хуулийг хэрэглэн шийдсэн анхны хэргүүдийн нэг байлаа. Түүгээр ч барахгүй энэ хэрэг хэвлэлийнхний анхаарлыг ихэд татсан тул олон нийт болон шийдвэр гаргагчдын ойлголтыг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байжээ. Дараа нь энэ байгууллагаас гаргасан сургалтын материалыг 1998 оны Эрүүл мэндийн шинэ хуулийг батлан гаргахын өмнө парламентын гишүүд нь уншиж судалсан байна. Энэ шинэ хуулиар өвчтөний

эрхийг баталгаажуулсан, эмийн болон сэтгэцийн эмчилгээ хийхдээ урьдчилан өвчтөнд мэдэгдэн зөвшөөрлийг авсан байх, өвчний тухай нууцыг хадгалах, найдваргүй тохиолдолд амь насыг хадгалах эмчилгээнээс татгалзах эрхтэй зэрэг заалтуудыг оруулжээ.

БҮЛЭГ 2

Монгол улс дахь Нийтийн эрх ашгийг хамгаалах Эрх зүйн механизм ба туршлага

- *Монгол Улсад нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөллөл хийх эрх зүйн боломжийн хүрээнд хийгдсэн бодит жишээ, кейс дээр тулгуурлан энэ үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал, тулгарч байгаа бэрхшээл сорилтын талаар орууллаа. Нийтийн ашиг сонирхлыг хуулиар хамгаалах хэрэгцээ өнөөгийн Монголын нийгэмд тулгамдаад байгаа бөгөөд энэ талаар ямар төрлийн стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа хийж байсан, тэдгээрийн ололт амжилт, алдаа дутагдлыг харуулж, анхаарах ямар асуудал байгааг доор нийтэлсэн хэргээр харуулахыг зорьсон болно.*

2.1. МОНГОЛ УЛСАД НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН МЕХАНИЗМ

Үндсэн хууль нь хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг төрийн дур зоргын үйлдлээс хамгаалах нийгмийн хэрэгцээ шаардлагаар бий болсон тул Үндсэн хуульт ёсны цөм нь хүний эрхийн тухай асуудал билээ.

Хүний эрхийг хангах асуудлыг Монгол Улсын Үндсэн Хуулийн 2 дугаар бүлэгт олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээтэй нийцүүлэн хуульчилсан нь Монгол Улсад хүний эрхийг хангах хууль зүйн баталгааны гол эх сурвалж нь болсон.

Үндсэн хуулийн 16.14 дэх хэсэгт,

- Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан

хохирлыг нөхөн төлүүлэх,

- Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх,
- Хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй гэж заасан билээ.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурор нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар Улсын дээд шүүхэд асуудал шилжүүлж болохоор³ заасан байна

Үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн хуваарилсан юм. Ингэснээр шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах онцгой чиг үүрэгтэй, хараат бус, эрх мэдлийн нэг салаа мөчир болон хуульчлагдсан юм.

Шүүхийн тухай хуульд, шүүх бол хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн хэмээн заасан. Энэхүү эрхэм чухал заалт нь гагцхүү шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлаар хангагдах ёстой. Шүүгчийн хараат бус байдал нь хүний эрхийг хамгаалахын тулд хуулийг хэрэглэхдээ хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын нөлөөнөөс үл хамааран шүүн таслах ажиллагааг бүрэн чөлөөтэй, бие даан хэрэгжүүлэх явдлаар илэрнэ.

Монгол Улсын Үндсэн хуулинд шүүгч хараат бус байж, зөвхөн хуульд захирагдана. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ ба Засгийн газрын гишүүн, улс төрийн намуудын болон олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэд хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэж заасан байдаг.

Ийнхүү шүүх нь Үндсэн хуулийн баталгаа болж, хүний эрхийг хамгаалахад өргөн хүрээтэй эрх, үүрэг хүлээжээ. Монгол Улсын иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох чиглэлээр дагнасан болон ердийн шүүх ажиллаж хүний эрхийг хамгаалж байдаг.

³ Монгол улсын үндсэн хуулийн 50.1.3 -р зүйл

Тухайлбал Үндсэн хуулийн цэц, Захиргааны болон Эрүү, Иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг шүүхүүд орно.

Эдгээрээс нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг нийгэмд бүхэлд нь ханган хамгаалахад захиргааны хэргийн шүүх, Үндсэн хуулийн цэц онцгой үүрэгтэй.

Захиргааны хэргийн шүүх

Хүний эрхийг зөрчих асуудал ихэвчлэн албан тушаалтануудын буруутай ажиллагаанаас үүсэн гардаг. Иймд иргэдийн эрхийг төрөөс хангах баталгаа болгож захиргааны хэргийн шүүхийг 2004 оноос байгуулсан билээ. Энэ шүүхэд нийтлэг эрх нь зөрчигдсөн гэж үзвэл иргэд дангаараа болон хамтарч гомдол гаргаж болно. Хамтарч гомдол гаргаж байгаа тохиолдолд нэхэмжлэгч нар нь өөрсдийн ашиг сонирхлыг төлөөлөх төлөөлөгчөө томилон итгэмжлэл болон бүрэн эрх олгож болох² заалт байдаг. Ингэхдээ иргэд өөрсдөө хуралдаж төлөөлөгчөө сонгож болохоос гадна Иргэдийн Нийтийн Хурлаас дээрх шийдвэрийг гаргаж болно.

Үндсэн хуулийн цэц

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн хууль болон төрийн өндөр албан тушаалтнуудын (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурал түүний гишүүд гэх мэт) шийдвэр, үйл ажиллагааг хянаж дүгнэлт гаргадаг шүүн таслах байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу буюу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэж байхаар хуульчлагдсан байна⁷.

Хүний эрхийн үндэсний комисс

Иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандахаас гадна Хүний эрхийн үндэсний комисст хандаж болно. Хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрх, эрх чөлөөний тухай Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, олон улсын гэрээнд заасан заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин

² Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22-р зүйл

⁷ Монгол улсын үндсэн хуулийн 66.1

хамгаалах, хөхүүлэн дэмжих үйл ажиллагаа явуулахаар 2001 онд байгуулагдсан.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл иргэн дангаараа буюу хамтарч Хүний эрхийн үндэсний комисст(ХЭҮК) гомдол гаргах эрхтэй. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны зүгээс хүний эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргаж⁵ иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх ажиллагаанд оролцож болдог.

Өмгөөлөл

Иргэд зөрчигдсөн эрхийнхээ талаар аль ч шүүхэд гомдол гаргах бүрэн эрхтэй. Тэгэхдээ шүүхэд тавьж буй асуудал нь аль шүүхэд харьяалагдаж болохыг судлан үзэх нь чухал. Монгол Улсын иргэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхийн ажиллагаанд оролцоходоо хууль зүйн мэргэжлийн туслалцаа авч болно. Хэрэв мэргэжлийн туслалцаа авах шаардлага гарвал өмгөөлөгчид хандаж туслалцаа авна. Өмгөөлөгчийн туслалцаа авах тэгш боломжийг хангахын тулд төлбөрийн чадваргүй иргэдэд шаардлагатай өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхийг Шүүхийн тухай хуулинд заасан. Үүнээс гадна Өмгөөллийн тухай хуулинд⁵ өмгөөлөгч бүр жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэдэд үнэгүй үйлчилгээ үзүүлэхийг үүрэг болгосон байна.

Төрийн бус байгууллагууд

Төрийн бус байгууллагууд эрх нь зөрчигдсөн иргэдэд эрх зүйн тулалцаа үзүүлдэг. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ТББ төлөөлөн хамгаалж болохыг 4 хуульчилж өгсөн байна. Түүнчлэн эрх нь зөрчигдсөн хохирогчид өөрсдөө буюу төлөөлөгчөөрөө дамжуулан эрхээ сэргээлгэж болох тухай эрх зүйн зохицуулалт бий болж байна.

⁵ Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 17.1.1-р зүйл

⁵ Монгол Улсын өмгөөллийн тухай хууль 12.3.8

⁴ Гэр бүлийн хуулийн 12.-р зүйл

2.2. МОНГОЛ УЛСАД НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: АНХНЫ АЛХАМ БА СОРИЛТУУД

Монгол Улсад нийтийн эрх ашгийг хөндсөн олон асуудал, тухайлбал, авилгал, газар хувьчлалын асуудал, гэр бүлийн хүчирхийлэл, агаарын бохирдол, байгаль орчны сүйрэл, хот, суурин дахь нийтийн эзэмшлийн газрын асуудал, ядуу хүмүүсийн эрх ашиг зэрэг асуудлууд хамгийн хурцаар тавигдаад байна. Иймээс нийтийн ашиг сонирхолыг хамгаалдаг төрийн бус байгууллагууд дараах чиглэлээр ажиллаж байна. Үүнд:

- Хүний эрхийн хэрэгжилтэнд мониторинг хийх
- Нийтийн ашиг сонирхолыг хамгаалах стратегийн өмгөөлөл хийх. Үүнд байгаль орчны асуудал, цөөнхийн бүлгийн эрх ашгийг хамгаалах, хүн худалдах гэмт хэргийн хохирогсдыг өмгөөлөх зэрэг тодорхой асуудлаар нийтийн ашиг сонирхлыг дэмжих, хамгаалах,
- Төлбөрийн чадваргүй хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлэх, тэдний төлөөлөгч болох,
- Эрх зүйн клиник сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Хуулийг боловсронгуй болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. Үүнд: хүн худалдах гэмт хэргийн асуудлаар Эрүүгийн хуулийн заалтыг өөрчлөх, Дээд шүүхийн тайлбар гаргуулах, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль батлуулах, хэрэгжүүлэх гэх мэт.
- Бүс нутгийн болон олон улсын шүүхэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зэрэг чиглэлээр ажиллаж байна.

Хэдийгээр нийтийн эрх ашгийг хамгаалах талаар тодорхой зохицуулалт хуулинд байхгүй боловч одоогийн хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд ашиг сонирхлыг хамгаалах алхмууд хийгджээ. Харин энэ үйл ажиллагааг системтэй зохион байгуулах нь чухал юм. Стратегийн өмгөөлөл нь хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг хэрэглэх ба тайлбарлах, нийгмийн институцийг шинэчлэх, нийгэм, улс төрд шинэчлэлт хийх зорилготой байдаг. Гэхдээ аливаа стратегийн өмгөөллийг хийхдээ дараах элементүүдийг агуулсан цогц үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж амжилтанд хүрдэг байна. Тухайлбал, өмгөөллийн зорилгоо

тодорхойлох; хариуцагч, шүүхийг зөв сонгох; хуулийн үндэслэлийг бүтээлчээр хэрэглэх; шүүгчдийг сургах, мэдээллээр хангах; гадны шинжээчдийг оролцуулах; ТББ-тай хамтран ажиллах, Үндсэн хууль болон олон улсын гэрээнд түшиглэх; хуулийн мэргэшсэн төвүүдтэй зөвлөлдөх; жишиг хэргүүдийг авч үзэх; олон улсын шүүхэд хандах гэх мэт.

Стратегийн өмгөөллийн элементүүдийг цогцоор агуулж чадахгүй байгаагаас зорьсон үр дүндээ хүрч чадахгүй хүч тарамдах, олон нийтийн дэмжлэгийг хүлээж чадахгүйд хүрэх, шүүхийн ажилтнуудыг сургах, мэдээллээр хангах ажлыг орхигдуулах, хариуцагч, нэхэмжлэгчээ зөв сонгож чадахгүй байх, хамтын ажиллагааны дутмаг байдал, үндэстний болон олон улсын эрх зүйн хэмжээг оновчтой хэрэглэх талаар туршлага дутах, хамгийн гол нь үйл ажиллагаанаас гарсан үр дүнгийн цаашдын үр өгөөжийг дэлгэрүүлэхгүй дарагдуулах зэрэг дутагдлууд байсаар байна. Үүнээс болж нийтийн ашиг сонирхлыг шүүхийн хүрээнд хамгаалах зорилготой хийгдэж байгаа стратегийн, өмгөөллийн үйл ажиллагаа амжилттай хөгжиж чадахгүй байна.

Монгол улсад хийгдсэн стратегийн өмгөөллийн зарим нэгэн туршлага, кейсүүдийг дор дурдлаа. Кейсүүдийг авч үзэхдээ стратегийн өмгөөллийн нийтлэг доорх 5 шинжээр дүгнэн үзлээ.

1. Урт хугацааны стратеги боловсруулсан байх
2. Нийгмийн өөрчлөлт авчрах зорилготой байх
3. Нийтийг дайчлах, хамрах олон талт арга, хэлбэрүүдийг хэрэглэсэн байх
4. Өргөн хүрээ бүхий үр нөлөө гаргахыг зорьсон байх
5. Нийгмийн хэрэгцээг удирдлага болгосон байх

Кейс 1. Монгол Улсын иргэн эх орондоо чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулсан нь

Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн эрчимжин, иргэдийн шилжих хөдөлгөөн тулгамдсан асуудлуудын нэг болсон. Хүний Эрхийн Үндэсний Комисс 2002 онд “Монгол улсын иргэд эх орондоо чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн хэрэгжилт” гэсэн судалгаа явуулсан байна. Судалгаанд

хотод шилжин ирсэн 18000 орчим иргэд хамрагдсанаас 60 хувь нь шилжин ирээд хотын бүртгэл хийлгэж чадаагүй байв. Судалгаагаар Улаанбаатар хотод шилжин суурьшигчид нь иргэний бүртгэл хийлгээгүйгээс эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдах, ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдлэх боломжгүйд хүрч байгаа нь тогтоогджээ.

Улаанбаатар хотод шилжин суурьшигчид иргэний бүртгэл хийлгэж чаддаггүй нэгэн шалтгаан нь хөдөө орон нутгаас нийслэл хотод шилжин ирж буй насанд хүрсэн хүнээс 50000 төгрөг, 18 хүртэлх насны хүүхдээс 25000 төгрөг хүртэл нэмэгдүүлсэн хураамж авах журмыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 46 тоот тогтоолоор баталжээ. Энэ тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрх” болон “Татварыг УИХ-аар бий болгоно” гэсэн татварын хуулийн заалтуудыг зөрчсөн гэж үзэн Хүний Эрхийн Үндэсний Комисс нь 2003 оны 3-р сарын 5-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхэд гомдлоо гаргасан байна. Энэхүү гомдлын нэхэмжлэгч нь Хүний Эрхийн Үндэсний Комисс, хариуцагч нь НИТХ байсан. Анхан шатны шүүх 344 тоот шийдвэрээрээ НИТХ-ын Тэргүүлэгчдийн Тогтоолыг хүчингүй болгосон байна. Давж заалдах шатны шүүх хариуцагчийн гомдлоор хэргийг хянаад анхан шатны шүүхийн шийдвэрийг 2003 оны 5 сарын 19-ний хуралдаанаар хүчингүй болгожээ. Нэхэмжлэгчийн гомдлоор хяналтын шатны шүүх Чингэлтэй дүүргийн шүүхийн шийдвэрийг зөв байна гэж үзсэн. Гэвч хариуцагч нар дахин дээд шүүхийн ерөнхий шүүгчид гомдол гаргаж дахин хэргийг Улсын дээд шүүх авч үзээд анхан шатны шүүхийн шийдвэр зөв гэсэн шийдвэр гаргажээ.

Энэхүү шүүхийн үшийдвэрийн үр дүнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хураамж авах тогтоол хүчингүй болж улмаар Улаанбаатар хотод шилжин ирэгсэд иргэний бүртгэл хийлгэх боломжтой болжээ. Ингэснээр шилжин ирэгсэд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдах, ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох зэрэг эрхээ эдлэх боломж бүрджээ. Түүнчлэн уг шүүхийн шийдвэрийн дараа Дархан-Уул, Төв, Орхон аймгуудын удирдлагууд шилжин

ирэгсэдээс төлбөр авч байх тухай гаргасан шийдвэрүүдээ өөрсдөө хүчингүй болгосон байна. Өөрөөр хэлбэл энэ шийдвэр нь зөвхөн Улаанбаатар хотод шилжин ирэгсэдэд хамаатай бус улс орны хэмжээнд хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үр нөлөөтэй байснаараа стратегийн өмгөөллийн шинжийг агуулж байгаа юм.

Кейс 2. Цэнхэрийн сумын алт олборлох үйл ажиллагаа

Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутаг дэвсгэр дээр Монгол газар ХХК нь 1999 оноос алт олборлох үйл ажиллагаа явуулжээ. Энэ хугацаанд тус нутгийн 19 гол ширгэж, байгаль орчин бохирдон, улмаар малын бэлчээр багасан, нутгийн малчин иргэдийн амьдрал ахуйд сөргөөр нөлөөлөх болсон байна. Нутгийн иргэд өөрсдийн эрх ашгийн төлөө эвлэлдэн нэгдэж 2005 оны 2-р сараас “Ариун Суврага” нэртэй хөдөлгөөн байгуулан уг компаний үйл ажиллагааны эсрэг тэмцэх болсон. Тус сумын хөрш зэргэлдээ орших нутгийн иргэдийн эртнээс хүндлэн дээдэлж, хайрлан хамгаалдаг онгон догшин газар болох Цэцэрлэг багийн “Нарийн хамрын гол” гэдэг нутагт Дархан уул аймгийн Монгол Алт ХХК 2000 оны 4 сард алт олборлох үйл ажиллагаа Цэнхэр сумын засаг захиргаанаас зөвшөөрөлгүйгээр эхлэх гэсэн боловч хайгуулын ажлын төлөвлөгөөгөө Засаг даргаар батлуулаагүй, газар олгох шийдвэр гаргаагүй байсан тул сумын улсын байцаагч Монгол Алт ХХК-ны техник хэрэгслийг лацдаж, нүүх шаардлага өгсөн байна. Цэцэрлэг багийн Иргэдийн Нийтийн Хурлаас Нарийн хамарт хайгуулын ажлыг хийлгэх боломжгүй харин уг талбайг сумын тусгай хэрэгцээнд авах нь зүйтэй гэж үзээд сумын ИТХ-д саналаа хүргүүлсэн ба 2000 оны 6 сарын 9-нд сумын ИТХ-ын 02 тоот тогтоол гарч дээрх талбайг сумын тусгай хэрэгцээнд авсан байна. Энэ шийдвэрээ кадастрын албаны зураг зүйн газарт явуулжээ. Иймээс тухайн үед Монгол Алт ХХК үйл ажиллагаагаа зогсоосон байна.

2002 оны 12-р сард Архангай аймгийн удирдлагаас Цэнхэр сумын ИТХ-ын 02 тоот тогтоол лиценз эзэмшигчийн эрхийг хаан боогдуулсан шийдвэр болсон тул эргэж харахыг хүссэн албан тоот ирүүлсэн бөгөөд сумын ИТХ дахин хэлэлцэх боломжгүй гэдэг тайлбараа аймгийн удирдлагад явуулжээ.

2003 оны 5 сарын 5-нд Монгол Алт ХХК нь Архангай аймгийн шүүхэд Цэнхэр сумын ИТХ-ын 02 тоот тогтоолыг хүчингүй болгох

нэхэмжлэл гаргасан бөгөөд үүнийг тус шүүх хэрэгсэхгүй болгосон байна. Гэтэл Монгол Алт ХХК давж заалдах өргөдлөө Хяналтын шатны шүүх буюу Улсын дээд шүүхэд гаргаж, улмаар тус шүүх 2003 оны 9-р сарын 23 нд сумын ИТХ-ын 02 тоот тогтоолыг хүчингүй болгосон байна. ИТХ-ын 02 тоот тогтоолыг хүчингүй болгуулсны дараа Монгол Алт ХХК нь лицензээ Монгол Газар ХХК-д зарсан байна.

Нутгийн иргэд уг талбайг усны эх, хагалбар мөн эсэхийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгохоор шийдэн, ШУА-ын Гео экологийн хүрээлэнгийн “Эко” судалгааны төвөөр судалгаа хийлгэсэн байна. Уг судалгааны тайланд Нарийн хамрын нутаг дэвсгэр нь усны хагалбар газар бөгөөд, хэрвээ уул уурхайн үйл ажиллагаа явуулбал цэвдэг хайлж, усны нөөц устах тухай, улмаар Суварга хайрхан уулын экологийн тэнцвэр алдагдах аюултай тухай, уг нутагт Монгол Улсын улаан номд орсон амьтан, ургамал байгаа тул хамгаалалттай газар болох тухай тодорхой өгүүлсэн байна. Иймээс тус нутгийн иргэд ИТХ-аа дахин хуралдуулж 2005 оны 3-р сард уг нутгийг сумын тусгай хэрэгцээний газар болгон авсан тогтоол гаргасан байна. Түүнчлэн Монгол газар ХХК 2005 оноос эхлэн Цэцэрлэг багийн ИНХ-аар уг газарт олборлолт хийх хүсэлтээ хэлэлцүүлж байсан ба ИНХ-аас 2005 оны 6 дугаар 29-нд Нарийн хамарт алт олборлох үйл ажиллагаа хийлгэхгүй гэсэн шийдвэрийг дахин гаргажээ.

Гэтэл Монгол газар ХХК уг газар олборлох үйл ажиллагаагаа эхэлсэн тул 2005 оны 5 сарын 30-нд нутгийн иргэд, компанийн хамгаалалтын албаны хооронд мөргөлдөөн гарч, талбай руу орсон иргэдэд галт зэвсэг хэрэглэн иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулсан байна. Тухайн үед иргэдэд галт зэвсэг хэрэглэсэн гэмт үйлдлийг цагдаагийн байгууллагаар шалгуулахаар гомдол гаргасан ч шалгахаас татгалзан прокурор хэргийг хаасан байна.

Мөн тухайн үед сумын ИТХ-аар Нарийн хамрын асуудлыг дахин авч хэлэлцээд алт олборлох ажиллагаа явуулахгүй гэсэн шийдвэрийг 2005 оны 6 дугаар 13-ны өдөр гаргасан байна. 2005 оны 7-р сарын 1-нд Цэнхэр сумын ИТХын тэргүүлэгчид дахин хуралдаж Монгол Газар ХХК-ны ашиглалт явуулах лицензтэй 686 га газраас 68 га газарт зөвшөөрөл өгөх тогтоол гаргав. 2005 оны 7-р сарын 19-нд дээрх шийдвэрийн дагуу Сумын засаг дарга захирамж

гаргаж газар ашиглах гэрээг 68 га талбайд хийх зөвшөөрлийг байгаль орчны улсын байцаагчдаа үүрэг болгосон байна.

2005 оны 7 сараас Хүний Эрх Хөгжил Төв нь компаний үйл ажиллагаанаас эрх зөрчигдөж буй малчин иргэдийн эрх ашгийг хамгаалахаар “Ариун Суварга” хөдөлгөөнд хууль зүйн зөвлөгөө өгөх, хуулийн өмгөөлөл үзүүлэхээр ажиллаж эхэлжээ.

2005 оны 8-р сарын 20-нд сумын засаг даргын шийдвэрийг баталгаажуулж өгөх хүсэлтийг Монгол газар ХХК аймгийн захиргааны хэргийн шүүхэд гаргаж Архангай аймгийн захиргааны шүүх уг хүсэлтийг баталгаажуулан, давж заалдах эрхгүйгээр захирамжийг гаргасан байна.

2005 оны 10-р сарын 5-нд Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх нутгийн иргэд, Хүний Эрх Хөгжил Төвийн өмгөөлөгч Д.Цэнд-Аюуш нарын гомдлоор 2005 оны 10-р сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд магадлалаар дээрх захирамжийг хүчингүй болгосон.

2005 оны 11-р сард Цэнхэр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 17 тоот тогтоол, Засаг даргын 55 захирамж нь илт хууль бус болсон гэж үзээд дээд шатны байгууллагуудад нь гомдол гаргасан. Гэвч аймгийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нар дээрх 2 шийдвэрийг хэвээр нь үлдээсэн хариуг өгсөн.

2006 оны 3 сард Архангай аймгийн Цэнхэр сумын Цэцэрлэг багийн иргэд, Ариун суврага хөдөлгөөн, өмгөөлөгч хамтран сумын засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрүүдийг илт хууль бус хэмээн үзэж захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан. Энэ гомдлыг Захиргааны хэргийн шүүх 2006 оны 5-р сарын 2-ны өдөр хэлэлцээд сумын ИТХТ-ын тогтоолыг илт хүчин төгөлдөр бус шийдвэр болохыг хүлээн зөвшөөрөн, Цэнхэр сумын засаг даргын 2005-07-19 ны өдрийн 55 тоот захирамжийг хүчингүй болгосон байна. 2006 оны 5 сард Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ 2006-05-22 ны өдөр хуралдаад “Нарийн хамар гол”-д олборлолт хийх газар усны зөвшөөрөл өгч хамтын гэрээ байгуулж ажиллахыг сумын засаг даргад даалгажээ.

Хүний Эрх Хөгжил Төв нь Ариун суврага хөдөлгөөний “Нарийн Хамрын гол”-д Монгол Газар ХХК-ны алт олборлох үйл

ажиллагааг явуулахгүй байх зорилгыг дэмжин, тэдэнд хууль зүйн туслалцаа үзүүлж, Монгол Газар ХХК-ны хууль бус үйл ажиллагааг зогсоож иргэдийн Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрхийг хуулийн хүрээнд хамгаалан хэрэгжүүлэх зорилготойгоор Архангай аймгийн сум дундын шүүхэд хандан стратегийн өмгөөлөл хийсэн. Энэхүү хэргийн нэхэмжлэгч нь Ариун суварга хөдөлгөөний гишүүд буюу орон нутгийн иргэд, хариуцагч нь Монгол Газар ХХК, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр Хүний Эрх Хөгжил Төвийн өмгөөлөгч байсан. 2005 оны 06 сарын 30 өдөр Архангай аймгийн Сум дундын шүүхэд тус аймгийн Цэнхэр суманд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа “Монгол газар” ХХК-ны үйл ажиллагааг түр зогсоолгох нэхэмжлэл гаргасан. “Монгол газар ХХК нь 2004 оны 12 дугаар сард АМГТХЭГ-ын Геологи уул уурхайн кадастрын албанаас Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг Нарийн хамрын гол гэдэг газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт хийх лицензүүдийг тус тус авсан боловч сумын захиргаанаас газар болон ус ашиглах зөвшөөрөл өгөөгүй мөн гэрээ хийгээгүй байхад үйл ажиллагаагаа эхлүүлснийг илрүүлсэн байна. Иймд шүүхэд нэхэмжлэл гаргаж дараах шаардлагыг тавьжээ.

1. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газар ашиглуулах тухай сумын засаг даргын захирамж гараагүй, гэрээ байгуулаагүй учир газар ашиглах эрх үүсээгүй.
2. Ус ашиглах эрх нь мөн үүсээгүй.
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу БОЯ-ны зөвшөөрөл байхгүй.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг орон нутгийн засаг захиргаанд өнөөдрийг хүртэл танилцуулаагүй байгаа учраас алт олборлох үйл ажиллагааг олон хууль зөрчиж үйлдэхээр завдаж, хүний эрхийн ноцтой зөрчил гаргасан.

Иймд “Монгол газар” ХХК-ний Нарийн хамар дахь үйл ажиллагааг зогсоож өгнө үү гэсэн нэхэмжлэл гаргасан.

Нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэж, 2005 оны 07 сарын 29-ний өдөр шүүх хуралдаан зарлагдсан боловч тухайн

нэхэмжлэгч иргэд хуралдаанд хүрэлцэн ирээгүй гэдэг шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах тухай шүүгчийн захирамж гарч, 2005 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан. Ингээд 2005 оны 8 сарын 24-ний өдөр Цэцэрлэг багийн Иргэдийн Нийтийн Хурлыг хийлгэхэд багийн бүх иргэн оролцсон бөгөөд энэ хурлаар нэхэмжлэгчдийг солисон байна.

Архангай аймгийн шүүх уг хэргийг Монгол Газар ХХК нь нутгийн иргэдээс гаргасан нэхэмжлэлийн үндэслэлийг хангасан тул, тухайн компанийн үйл ажиллагааг зогсоох шаардлагагүй хэмээн үзэж, нэхэмжлэлийн үндэслэлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргасан байна.

Түүнчлэн өмгөөлөгч хууль бусаар гаргуулсан захирамж, тогтоолыг хүчингүй болгох асуудлаар шүүхэд гомдол гаргах, иргэдийн хөдөлгөөнийг дарамтлан, хүч хэрэглэн тараахыг оролдсон Монгол Газар ХХК-ны хамгаалалтын албаны ажилтнуудын зүй бус үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаар шалгуулах хүсэлт гаргах, мөн иргэдийн хөдөлгөөнийг барьсан хаалтыг хүч хэрэглэн авч Монгол Газар ХХК-ны үйл ажиллагаанд тусалсан цагдаагийн байгууллагын ажилтнуудын зүй бус үйл ажиллагааг прокурорын байгууллагаар шалгуулах хүсэлт гаргах зэрэг арга хэмжээ авсан байна.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд хууль бус захирамж гаргасан Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн гаргасан хууль бус захирамжийг хүчингүй болгосон ба мөн бусад хууль бус захирамж, тогтоолыг хүчингүй болгуулах шүүхийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Энэ хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхийн төлөө иргэний нийгмийн байгууллагуудын үр ашигтай хамтын ажиллагааны түншлэл бий болгохыг зорьсон хэрэг юм. Нийтийн ашиг сонирхлыг хууль зүйн хүрээнд үр дүнтэй хамгаалах жишиг бий болгох зорилгыг тавин үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж эхэлсэн хамтын ажиллагаа юм.

Архангай аймгийн Цэнхэр сумын Нарийн Хамарт нутаглаж буй иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр хууль зүйн хүрээнд ажиллахад олон хүндрэлтэй асуудалтай тулгарч, түүнийг даван туулах тактикийн болон стратегийн үйл ажиллагааг

хэрэгжүүлэх зэргээр туршлага хуримтлуулан ажиллаж байна. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөх үйл ажиллагаа нь бусад өмгөөллийн үйл ажиллагаанаас ихээхэн онцлог өмгөөлөл тул нэхэмжлэгч буюу иргэний хөдөлгөөний төлөөлөгчидтэй ойр ажиллаж, нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй байх нь хамгийн чухал гэдгийг ойлгосон явдал юм. Өөрөөр хэлбэл, иргэний нийгмийн хөдөлгөөнийг төлөөлөн нэхэмжилж байгаа гишүүдийг гадны нөлөөнөөс хамгаалах, нөлөөнд автуулахгүй байх, үзэл бодлоо өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг давхар төлөвлөн ажиллах нь нэн чухал болохыг энэ хэрэг харуулсан. Энэ хэрэг дээр анхаарал татсан гол асуудал нь орон нутгийн шүүх хүний эрхийн мэдлэг, мэдрэмжээр сул, мөн иргэд эрх зүйн мэдлэгээр бага, хуулийн байгууллагад үл итгэх явдал газар авсанд оршино.

Кейс 3. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх зөрчил болон учирсан хохирлыг шүүхээр барагдуулсан нь

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт 1995 оны 12-р сарын 31-ний өдөр хүн амины хэрэг гарчээ. Цагдаагийн алба хаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчиж нотлох баримт цуглуулах, эрүүдэн шүүх, хуульд заасан хугацааг хэтрүүлэн хорих, шүүх нотлох баримтанд зөв үнэлгээ өгч чадаагүй зэрэг шалтгааны улмаас хүн амины хэрэгт хилсээр шүүхээс 3 удаа цаазаар авах ял, 3 удаа 25 жилийн хорих ялаар шийтгүүлж түүнээс 5 жилийг гянданд хоригдохоор таслан шийтгэх тогтоол гарч гянданд уг ялыг эдэлсэн байна.

Энэ хэргийн хохирогч түүний ар гэрийнхэний хүсэлтээр өмгөөлөгч Н. Ламжав хавтас хэргийн материалтай танилцаж үзээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хуулийн байгууллагын ажилтнууд хууль зөрчсөн гэж үзэн, Завхан аймгийн шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, яллагдагчийг цагаатгах зорилгоор доорх үндэслэлээр шүүхэд хандсан байна.

- Шүүхээс гэм буруугүй хүнийг шийтгэхгүй байх,
- Нотлох баримтыг цуглуулахдаа ЭБШХ-ийн шаардлагыг чанд сахиулах,
- Цугларсан нотлох баримтыг зөв бодитой шударга үнэлдэг байх,

- Алба тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэд нөхөн төлбөр авдаг болох,

Энэ хэргээр гэм буруугүй этгээдийг хангалттай бус нотлох баримтанд тулгууран шийтгэж буй ажиллагааг таслан зогсоох, хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүний эрхийг зөрчиж байгааг илрүүлэх, цаашид энэ байдлыг таслан зогсоох, алба тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэд нөхөн төлбөр авдаг жишиг бий болгох зорилго тавьсанаараа энэхүү хэрэг нь стратегийн өмгөөллийн шинжийг агуулж байна.

Өмгөөлөгчийн зүтгэлийн үр дүнд 2002 оны 9-р сарын 25-ны өдөр Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалаар холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шоронгоос сулласан байна.

Энэ хэргийн үр дүнд хариуцлагагүй, хайхрамжгүй үйл ажиллагаанаас хүний эрхийг ноцтой зөрчин хэрэг буруу шийдвэрлэсэн хууль сахиулах байгууллагын ажилтанд хариуцлага тооцох хуулийн заалт байдаг боловч хэрэгждэггүй практикийг илрүүлэн гаргасан ач холбогдолтой болжээ.

Энэхүү цагаатгасан шүүхийн үшийдвэрийн дараа хохирогч 7 жил шахам хүнд нөхцөлд хоригдож өөрөө болон ар гэрийнхэн нь сэтгэл санааны болоод эд материалын хохирол амссан тул уг хохиролыг нөхөн барагдуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Энэ хэрэг нь хуулийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэдийн хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх хуулийн заалтыг анх удаа хэрэгжүүлэх нь хуульд нийцсэн асуудал гэж үзээд Хүний Эрхийн Үндэсний Комисс 2004 онд хохирогчийн хүсэлтийг үндэслэн түүний нэрийн өмнөөс Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхэд төлөөлөн 53.699.225 төгрөгний нэхэмжлэл гаргажээ. Энэ хэрэгтнэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Хүний Эрхийн Үндэсний Комисс байсан ба хариуцагч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389-р зүйлийн 1, 390-р зүйлийн 2-т заасныг үндэслэл болгон Санхүү эдийн засгийн яамны төрийн сангийн газар байжээ.

Нэхэмжлэгчид учирсан хохирлыг хэд хэдэн үндэслэлээр тооцсон байна. Үүнд:

1. Нэхэмжлэгч ажил хөдөлмөр эрхлэн амьдарч байсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцоход 1610625 төгрөгний цалин авах ёстой байсан.
2. Нэхэмжлэгч хоригдохын өмнө 185 толгой малтай байсан. Иймээс нэхэмжлэгч малаа өсгөж үржүүлсэн бол мэргэжлийн хүмүүсийг оролцоотойгоор тооцоолсноор нийт 20988600 төгрөг болох байсан.
3. Хэдийгээр олон өмгөөлөгч авч хөлс төлж байсан боловч нэг л өмгөөлөгчид хөлс төлсөн тухай баримт байсан. Өмгөөлөгчийн хөлсөнд 500000 төгрөг төлсөн.
4. Нэхэмжлэгч хилс хэрэгт холбогдсоноос болж эцэг эх, ах дүүс нь Завхан-Улаанбаатарын хооронд нийт 30 удаа онгоц, машинаар явсаныг машины зардлаар тооцоход 600000 төгрөг болсон.
5. Гурван удаа онцгой ял авч байснаас сэтгэл санаа, эрүүл мэндээр маш их хохирсон тул 29,000,000 сая төгрөг гэж тооцсон.
6. Сонин хэвлэлээр алуурчин хэмээн хэлэгдэн орон даяар цацагдаж байсан тул нэр төрөө сэргээлгэхэд 1000000 төгрөг гэсэн үндэслэлүүдийг гаргаж хохирлоо нэхэмжилсэн байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх Иргэний хуулийн 497-р зүйлийн 1-д зааснаар СЭЗЯ-ны Төрийн сангийн газраас 18010625 төгрөг гаргаж нэхэмжлэгчид олгох шийдвэрийг гаргасан байна.

Энэ хэрэг нь хуулийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэдийн хохирлыг төлүүлэх хуулийн заалтыг анх удаа хэрэгжүүлэх, цаашид хохиролыг нөхөн төлүүлдэг жишиг тогтоох, улмаар хүний эрхийн зөрчлийг гаргахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болсноороо олон нийтийн эрх ашгийг хамгаалж байгаа тул стратегийн өмгөөллийн шинжийг агуулж байна. Түүнчлэн, хохирогчдыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулж өгсөн ач холбогдолтой болжээ. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашигласан нь хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг болохыг олон нийтэд мэдэх боломжийг бий болгосон байна.

Кейс 4. Амьд явах эрхийг зөрчсөн хохирлыг шүүхээс нэхэмжилсэн нь

Сэжигтэн Г.Ганбат нь Төв аймгийн цагдаа, прокурорын байгууллагын ажилтнуудын хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас 11 сар цагдан хоригдож байхдаа сүрьеэ өвчин тусч эрүүл мэнд нь доройтсон байна. Энэ хугацаанд Г.Ганбат олон удаа эмнэлгийн тусламж авах хүсэлт гаргаж байсан ба ар гэрийнх нь эрүүл мэндийн байдлын улмаас батлан даалтанд гаргуулах хүсэлт тавьж байсан боловч тухайн үед хэрэг хариуцаж байсан албан тушаалтнууд үл хайхран хүнд нөхцөлд хорьж байснаас сүрьеэ, тураалын хүнд хэлбэрээр нас барсан байна. ХЭҮК энэ хэргийг хүний амьд явах эрх, эмнэлгийн тусламж авах эрхийг ноцтой зөрчсөн хэмээн дүгнэсэн юм. Энэ хэргийн дагуу Эрх Зүйн Шинэтгэлийг Дэмжих Хуульчдын Төвөөс /ЭЗШДХТ/ 2002 онд Төв аймгийн Цагдаагийн газар болон Прокурорын газарт амьд явах эрхийн зөрчлийн хохирлыг нэхэмжилсэн байна.

Стратегийн өмгөөллийн зорилго нь зөрчигдсөн хүний эрхийг шүүхээр сэргээлгэн тогтоолгож цагдаа, прокурорын байгууллагын ажилтнуудыг хүний эрхийг хүндэтгэх, хуулийн дагуу ажиллахад нөлөөлөхөд хувь нэмэр оруулах явдал байжээ.

Энэ хэргийн нэхэмжлэгч нь хохирогчийн гэр бүл, өмгөөлөгч нь Эрх Зүйн Шинэтгэлийг Дэмжих Хуульчдын Төв, хариуцагчаар Төв аймгийн цагдаа, прокурорын газар байсан байна.

Өмгөөлөгч Иргэний хуулийн 377 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй гэсэн заалт, мөн Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай Пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенци, Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд зэрэг гэрээ конвенциор тогтоосон стандартыг үндэс болгон шоронд хоригдож ял эдлэж байхдаа амьд явах эрх нь зөрчигдөж, эмнэлгийн тусламж авч чадахгүй байсаар нас барсан тул буруутай этгээдүүдээс ар гэрийнхэнд нь 30 сая төгрөг олгуулахаар нэхэмжлэл гаргасан байна.

Төв аймгийн шүүх, нийслэлийн шүүх, Улсын Дээд шүүх зэрэг хэд хэдэн шатны шүүхээр хэргийг хэлэлцүүлсэн боловч хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг

хэрэгсэхгүй болгохдоо Ганбат хэрэг үйлдсэн нь нотлогдож байгаа бөгөөд хууль бусаар цагдан хоригдоогүй тул нэхэмжлэлийг хангах шаардлагагүй хэмээн үзжээ.

Иргэний хуульд зөвхөн хууль бусаар цагдан хоригдсон хүний нөхөн төлбөрийг гаргуулахаар хуульчилж, харин хуулийн дагуу хоригдоод хорих газар эрх нь зөрчигдсэн хүний хувьд нөхөн төлбөр олгуулах заалт хуульд байхгүй байгаа хуулийн хийдэл энэ мэт хохирсон хүмүүсийн эрхийг сэргээхэд саад учруулж байна гэж өмгөөлөгч дүгнэсэн байна.

Кейс 5. Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн

Монгол Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Ингэхдээ УИХ-ын гишүүд 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын даргад өргөн барьж, тухайн чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байхад гэнэт буюу маргааш нь хэлэлцүүлэггүйгээр шууд баталжээ. Ерөнхийлөгчтэй зөвшилцөөгүй, Үндсэн хуулийн цэцээс санал аваагүй юм. 1992 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь төрийн эрх мэдэл хуваарилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гажуудуулан улмаар хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг зөрчихөд хүргэж болзошгүй гэж үзэн өмгөөлөгч, доктор, профессор С. Нарангэрэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргажээ.

Уг гомдолд нэхэмжлэг нь Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24 ны өдөр баталсан “Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт” нь үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шудрага ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцэж байвал зохино” зэрэг заалтыг зөрчсөн байна гэж үзжээ. Энэхүү гомдлоор 1999 онд үндсэн хуульд оруулсан нэмэлт нь Монголын нийгмийн улс төр, эрх зүйн амьдралд дараахи сөрөг үр дагавартай болохыг олон нийт, Үндсэн хуулийн цэцэд харуулахыг эрмэлзсэн байна. Түүнчлэн дараах үндэслэлийг нэхэмжлэлдээ гаргажээ.

- Энэ нэмэлтээр Улсын Их Хурал ба Засгийн газар нь угтаа нэг байгууллага болж УИХ нь Засгийн газарт хяналт тавих боломжоо алдаж засгийн газарт бүх “эрх мэдэл” төвлөрөх болно.
- Сонгуульд ялсан намын удирдлага, УИХ, Засгийн газар нэг болж, намын дээд удирдлагад гарсан хүмүүс УИХ, ЗГ-ын гишүүнд нэр дэвшихийг улайран хөөцөлдөж, эдгээрээс хамаарч нам төвтэй улс төрийн тогтолцоо бүрэлдэх аюул нүүрлэнэ.
- Нууц санал хураалтыг ил болгосноор зөвхөн намын дарга ба түүний ойр дотнын хэдхэн цөөн тооны хүмүүсийн бодлогоор төр засгийн удирдах дээд албан тушаалтныг сонгох буюу томилох ажиллагаа явагдаж тэдний таалалд нийцээгүй ямар ч шударга, чадвартай хүнийг гаргаж ирэхгүй болно.
- УИХ-ын чуулганы ирцийг бууруулсан нь УИХ-аас батлан гаргах хууль болон бусад шийдвэрт нийт иргэн, улсын ашиг сонирхлыг тусган илэрхийлэх боломжийг улам багасгаж, улмаар УИХ-д хариуцлагагүй байдал ноёрхуулах, алдаг оног хуралдсан болох, хууль тогтоох үйл ажиллагаа чанаргүйтэх байдалд оруулж болзошгүй.
- УИХ-ыг 50-аас доошгүй хоног хуралдуудах болсон нь УИХ-ын байнгын ажиллагаатай байх шинжийг алдагдуулж, улс орны амин чухал хойшлуулшгүй ажил хэрэг цалгардах, эзэнгүйдэх байдалд хүргэх эрсдлийг агуулсан.

Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн 2000 оны 3 дугаар сарын 15 нд хэлэлцэн 1999 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгосон. Мөн 2000 оны 11 дүгээр сарын 29-нд цэц их суудлын хуралдаанаараа хэлэлцэн өмнө нь гаргасан дүгнэлтээ бататгасан тогтоол гаргажээ.

БҮЛЭГ 3

Стратегийн өмгөөлөл хийх арга зүйн Зөвлөмж

- Энэхүү бүлэгт өмгөөлөгчид нь нийтийн эрх ашгийг хамгаалан стратегийн өмгөөлөл хийхэд зориулан арга зүйн зөвлөмжийг орууллаа.

3.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙГ СОНГОХ НЬ

Нийтийн эрх ашгийг хамгаалахад өмгөөлөл хэр тохирох вэ гэдгийг шийдвэрлэхэд дараах хэдэн асуудалд анхаарал тавих хэрэгтэй.

- *Хүчин төгөлдөр байгаа хуулийн үйлчлэлийг өргөжүүлэх, хуулийн өмнө тэгш байх зарчмыг хангах, хуулийг хуулийн дагуу зохих ёсоор хэрэглэхийг шаардах хэрэгтэй бол*

Үүнд хуулийг шинэлэг байдлаар тайлбарлах болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг өмнө гарч байгаагүй хэлбэрээр хэрэглэх зэрэг хамаарна.

- *Тухайн асуудалд холбоотой хуулийн хэрэгжээгүй зүйл заалт байгаа бол*

Хувь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан хууль тогтоомж байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гарч байгаагүй байж болно. Ийм асуудлаар өмгөөлөл явуулснаар тухайн асуудлаарх үндэсний хууль тогтоомжийн талаар үндэслэлтэй мэдээллийг шүүхэд өгөх бөгөөд ингэснээр шүүх нааштай шийдвэр гаргахад нөлөөлөх үр дүнтэй арга болно. Мөн тухайн хууль тогтоомжийн талаар давтан өмгөөлөл явуулснаар хуулийн хэрэгжилт илүү үр дүнтэй болдог.

- *Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн томоохон хэмжээний ач холбогдол бүхий заалт байгаа бол*
- *Тухайн хуулийн хэрэгжилтийн асуудлаар төр засгийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц олон улсын эрх зүйн хэм хэмжээ байгаа бол*
- *Цаашид хүний эрхийг хамгаалах жишиг тогтоох шаардлагатай бол*

Хүний үндсэн эрхийг зөрчсөн асуудлаар шүүхийн ажиллагаа явуулснаар хүний эрхэд суурилсан эрх зүйг бий болгохыг дэмжинэ.

- *Өмгөөллөөр дамжуулан олон нийтийн боловсрол, иргэдийн чадавхийг нэмэгдүүлэх хэрэгтэй бол*

Өмгөөлөл амжилтанд хүрээгүй байсан ч түүний явцад хийсэн үйл ажиллагаа нь олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж чаддаг.

Хэрэг үүсгэх болон бэлтгэх үйл явцад иргэдийг оролцуулбал шүүхийн тогтолцооны хүч нөөц болон дутагдалтай талыг шууд олж харах боломж олгосон танин мэдэхүйн үйл явц болдог. Өмгөөллийн явцад иргэдийг оролцуулснаар өөрсдийн нь эрхийн зөрчсөний төлөө хариуцлага тооцох иргэний нийгмийн чадавхийг давхар бэхжүүлж өгдөг.

3.2. СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ШАЛГУУР ХЭРГИЙГ СОНГОХ НЬ

Стратегийн өмгөөллийн шалгуур хэрэг болгон сонгон, шүүхэд хандахаа тодорхойлохдоо доорхи хүчин зүйлсийг анхаарна. Үүнд:

- Орон нутгийн ямар нөөц боломжууд байна вэ?
- Хэр хэмжээний зардал гарах вэ?
- Энэ хэргийг шийдвэрлэх шүүгч, шүүхийн нэр хүнд ямар вэ?
- Тухайн хэрэгтэй холбоотой асуудалд хэвлэл мэдээллийнхэн хэрхэн хандаж байна вэ?

- Нэхэмжлэл гаргагчид өөр ямар хуулийн боломж бий вэ?

Эдгээр асуудлыг тунгааж үзсэний эцэст тухайн хэрэг дээр өмгөөлөл хийх нь тохиромжгүй гэж үзэж болно. Нэг бол их өндөр өртөгтэй, эсвэл үр дүн нь сөрөг байхаар байж болно. Мөн өөр байгууллагаар энэ хэргийг шийдвэрлүүлбэл илүү тохиромжтой ч байж болно. Хэрвээ стратегийн өмгөөлөл хийх нь нийтийн ашиг сонирхлын төлөө хамгийн сайн хувилбар болно гэсэн шийдвэр гарвал дээрхи асуултын дагуу стратеги тактикаа боловсруулахаар дахин хэлэлцдэг. Мөн амжилтанд хүрэх боломжийг дээд зэргээр ашиглахын тулд доорхи асуултуудыг анхааран үзэх хэрэгтэй.

- Үйлчлүүлэгчийн гол зорилго нь юу болох болон үйлчлүүлэгч зорилгодоо хүрэхэд хуульчид ямар туслалцаа үзүүлэх вэ?

- Зорилгодоо хүрэхийн тулд үйлчлүүлэгч хэр их хүчин чармайлт гаргаж чадах вэ? /цаг хугацаа, зардал, боломжит эсэргүүцэл тулгарч болох /

- Сонгосон хэргийн нэхэмжлэгчээс ямар баталгаа байгааг анхаарах хэрэгтэй. Учир нь стратегийн өмгөөллийн хамгийн гол аюул нь маш их хичээл зүтгэл, цаг хугацаа зарцуулсны дараа үйлчлүүлэгч эсрэг талын сүрдүүлэг, олон нийтийн хараанаас залхах зэрэг хүчин зүйлүүдээс болж шүүх ажиллагааг дуусгалгүй орхих явдал юм. Тиймээс нэхэмжлэгч шүүх ажиллагаанд дуустал оролцох хариуцлага хүлээсэн эсэх

- Үйлчлүүлэгчийн болон эсрэг талынх нь давуу ба сул тал юу вэ?

- Талуудын нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл? Тэдгээр нь хэр зэрэг хүчтэй вэ?

- Эсрэг тал нь хэн болон тэдний хүч, бололцоо ямар вэ?

- Хэргийг нотлоход хэр хэцүү байх вэ? Нотлох баримт бий юу? олдох уу?

- Шүүх хуралдаанд ялах буюу ялагдсанаар бодлогын хувьд ямар сөрөг үр дүн гарах вэ?

- Энэ хэргийг шийдвэрлүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ямар нөлөөтэй вэ? Олон нийтийг илэрхий цочроосон ямар нэг хууль бус зүйл байна уу?

- Эрх зүйн үндэслэлүүд энгийн тодорхой байж чадаж байна уу?

Авах арга хэмжээ нь хэрэгжүүлэхэд хялбар уу? гэх мэт.

Хэрэв уг хэрэг шүүхэд ялагдах магадлалтай боловч өмгөөлөл хийснээр асуудлыг тодруулж, өргөн хүрээний кампанит ажилд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байгаа үед зарим нэг нэмэлт зүйлсийг анхаарах шаардлага гарна. Үүнд:

- Хэрэг амжилттай шийдэгдэх магадлал бага байгаа боловч үйлчлүүлэгчийн хэргээ үргэлжлүүлэх хүслийг хуульч дэмжих шаардлага байна уу?
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгч урт удаан хугацаагаар давж заалдахыг хүсэж байна уу?
- Энэ хэргийг эцэст нь хүргэх санхүүгийн хангалттай чадавхи байна уу?
- Энэ хэргийн талаар бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллагад хандаж болох уу? Хэрвээ хандаж болохоор бол үндэсний шүүхийн тогтолцоог бүхэлд нь дуусгах ёстой бөгөөд, ингэж дуустал явснаа харуулах нотолгоотой эсэх
- Шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох магадлалтай бол түүнийг өөрчлөх боломж байна уу? Нэг хэргийн хүрээнд хэд хэдэн нэхэмжлэлийг гаргах боломжтой эсэх
- Энэ хэргийг шүүхэд өгснөөр ялагдсан ч гэсэн тодорхой хэмжээний үр дүн гарч болох. Тухайлбал, өмгөөллийн явцад үйлчлүүлэгчийн хохирсон зүйлсийн хариуд түүнийг давж гарахаар илүү чухал шалтаг гарах уу?
- Энэ хэрэгт нэмэр болох эрх зүйгээс өөр ямар үйл ажиллагаа явуулж болох вэ? Ийм үйл ажиллагаа нь шүүхэд гомдол гаргах ажиллагааны хүчийг сулруулах уу? Ийм үйл ажиллагаа нь нөхцөл байдлыг тогтвортой өөрчлөх үү?
- Хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлөх эсэхээс хамаарахгүйгээр нийт үйл ажиллагааны стратегийн талаар үйлчлүүлэгчид мэдэгдэх ёстой юу? Стратегийн цаад зорилгын талаарх мэдээллийг үйлчлүүлэгчид өгөхгүй байх нь ёс зүйд нийцэх үү? Хуульч өөрийн стратегийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгчээс нууцлах нь хууль ёсны зүйл үү? Стратеги боловсруулахад оролцуулснаар үйлчлүүлэгч хөгжиж байна уу?

Эцэст нь тохиромжтой хэргийг олох гэж хүчлэн оролдож

болох ч, аливаа хэрэг нь байгууллага, ажиллаж байгаа хүмүүсээс ихээхэн хамаардаг. Бүтээлч өмгөөллийн ажиллагаа нь харьцангуй санаандгүй байдлаар тааралдсан хэргүүдийг ч өргөн хүрээтэй, удаан үргэлжлэх үр нөлөөнд хүргэж чаддагийг санахад илүүдэхгүй.

Шалгуур хэргийг сонгохдоо шүүх хуралдаанаар үгүйсгэгдэх аргагүй онцлог хэргийг сонгох нь чухал байдаг. Тухайлбал, ямар нэг маш ноцтой асуудлаар, мөн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн үндсэн эрхүүдэд маш ойр дөт хэрэг байж болно.

Нэхэмжлэгчийг зөв сонгох

Шүүх ажиллагаанд нэхэмжлэл гаргагч нь хууль бус ажиллагааны улмаас бие махбодь, санхүү болон сэтгэл санааны хувьд ямар нэг байдлаар хохирсон, зарга мэдүүлэх хүсэлтэй хүн байх шаардлагатай. Уг нэхэмжлэгчийн хэргийн онцлог нь шүүх түүний талд орохоор байх ёстой. Жишээ нь, хүчирхийллийн хэмжээгээр эсвэл баримт нотолгооны байдал нь шүүх өөрөө нэхэмжлэгчийн талд ашигтай шийдэл гарахуйц байх гэх мэт. Мөн нэхэмжлэгчийн итгэл хүлээх

Египтэд хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэргүүд маш маргаантай байдаг бөгөөд нэхэмжлэгчид шүүхийн үе шат дуусахаас өмнө хэргээ орхиж явдаг. Иймээс Хууль зүйн төвийн хуульч Хисхам Мубарак нь ижил төстэй хэд хэдэн хэргийг нэг зэрэг шүүхэд мэдүүлснээр эдгээрээс аль нэг нь Дээд Шүүхэд хүрч болох магадлалыг нэмэгдүүлсэн.

Болгарт ажилладаг Хельсинкийн Хороо жижиг гэмт хэргүүдийг шүүхэд мэдүүлэлгүйгээр шууд хорихыг зөвшөөрсөн хуулийн эсрэг хамтарч ажиллах үйлчлүүлэгчийг хайсан байна. Гэтэл ялаа нэгэнт эдэлсэн хүмүүс дахиж төр засагтай ямар нэг байдлаар холбогдохоос зайлсхийдэг болсон байлаа. Гэвч тус байгууллага энэ асуудал дээр ажиллахаар тууштай зогссон байна. Ингээд үйлчлүүлэгч олохын тулд нилээдгүй хэмжээний хөрөнгө зарцуулжээ. Тэд дурамжхан байгаа үйлчлүүлэгчдээ ятгаж урамшуулахын тулд хүний эрхийн төлөө ажилладаг Хорооныхоо стратегийг танилцуулж байсан нь гол арга болсон байна

байдал, өөртөө итгэх итгэл, шударга, найдвартай, шийдэмгий, тууштай чигч байдал, сэтгэлийн тэнхээ гэх мэт хувийн зан чанарууд нь шүүх хуралдаан болоод өмгөөллийн ажиллагааны аль алинд тус дөхөм үзүүлдэг. Мөн нэхэмжлэгч уг хэрэгт дуустал нь явах хүсэлтэй эсэхийг нь анхнаасаа тодорхойлох нь чухал. Энэ асуудалтай холбоотой Өмнөд Африкийн бүгд найрамдах улсын сонирхолтой нэг жишээг энд дурдъя. Сульдаж ядарсан, улмаар хүндээр өвдөж болзошгүй охин, үхлүүт өвчтэй өвгөн хоёр улсын эрүүл мэндийн халамжийн газраас тусламж авч чадахгүй байгаагаас эрүүл байх эрхээ эдлэж чадахгүй байна хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Хэдийгээр хоёулаа эрүүл байх эрхтэй боловч, охины хэргийг шүүх хүлээн зөвшөөрөхөд илүү амар байх байсан. Харамсалтай нь өвгөний хэрэг шүүхэд түрүүлж хүрсэн бөгөөд шүүх хөрөнгө мөнгөний гачигдал болон энэ эрхийн хэрэгжилтийн онцлогоос шалтгаалан уг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Иймээс зөв нэхэмжлэгчийг сонгох нь стратегийн өмгөөлөлд их чухал байдаг.

Тухайн үйлчлүүлэгчийг сонгосон нь зөв байсан ч түүнийг уг асуудлаар шүүхээр тууштай явахыг ятгахад хэцүү байж болно. Гэхдээ, зөв стратеги боловсруулснаар үүнийг хэрэгжүүлж болно.

Шалгуур хэргийг боловсруулах, шүүхэд нэхэмжлэх нь

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажилладаг аль нэгэн байгууллага ямар асуудлаар, хэнтэй ажиллахаа сонгож мөн стратегийн өмгөөлөл хийх нь хамгийн сайн арга гэдгийг шийдвэрлэсэн бол тухайн хэргийг хэрхэн авч явах арга замаа сайтар боловсруулах хэрэгтэй

Анхаарах зүйл:

Шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх үйл явц маш их зардал шаарддаг болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Шүүх хуралдааны болон нотлох баримт цуглуулах зардал мөн захиргааны бусад зардал нэмэгдээд маш их болдог. Иймээс уг хэргийг шүүхээр яаж амжилттай шийдвэрлүүлэх вэ гэдэг стратеги боловсруулахаас гадна уг хэргийг хэрхэн санхүүжүүлэх вэ гэдэг стратегийг эртнээс боловсруулах хэрэгтэй.

байдаг. Тухайн хэргийн талаар амжилт олох боломжийг аль болох бүрэн хэмжээнд нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг анхаарах ёстой:

1. Өмгөөллийн зорилгоо тодорхойлох
2. Хариуцагчийг зөв сонгох
3. Шүүхийг сонгох
4. Хуулийн үндэслэлийг бүтээлчээр хэрэглэх
5. Шүүхийг сургах, мэдээллээр хангах
6. Гадны шинжээчдийг оролцуулах
7. ТББ-тай хамтран ажиллах
8. Үндсэн хууль болон олон улсын гэрээнд тулгуурлах
9. Хууль зүйн мэргэшсэн төвүүдтэй зөвлөлдөх
10. Жишиг хэргийг хэрэглэх
11. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг ашиглах, олон улсын шүүхэд хандах

Өмгөөллийн зорилгоо тодорхойлох

Хуульчид, өмгөөлөгчид тухайн хэрэг дээр стратеги боловсруулж, ажлаа эхлэхээс өмнө өмгөөллийн зорилгоо сайтар тодорхойлох ёстой. Тухайн хэрэг дээр боломжит үр дүнгүүдийг жагсааж бичих хэрэгтэй. Үүн дотор зарим талаар эерэг, сөрөг үр дүнгүүдийг гаргаж ирэх нь стратеги боловсруулахад нэн тустай. Ингэх нь өмгөөллийн ерөнхий зорилго нийтийн ашиг сонирхлыг хамгаалах кампанит ажилтай хэрхэн нийцэж байгааг үнэлж үзэхэд тустай байдаг. Тухайн байгууллага нь хэтийн чиглэл, зорилгоо сайтар боловсруулсан байх хэрэгтэй ба ийм нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан өмгөөлөл бүр тухайн байгууллагын зорилготой нийцэж байх ёстой. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан үйл ажиллагаа бүр бодитой зорилготой байдаг.

Хариуцагчийг зөв сонгох

Хариуцагчаа зөв сонгоход нь тийм ч амар биш байдаг. Энэ нь ялангуяа төрийн албан хаагчийн буруутай ажиллагаатай холбоотой асуудлаарх хэрэгт бүр ч илүү хамаатай юм. Жишээ нь, цагдаагийн

ажилтны буруу ажиллагааны төлөө хэнийг хариуцлагад татах вэ, Хууль зүйн сайдыг уу, түүний хэлтэс тасгийг уу, орон нутгийн цагдаагийн тасгийг уу эсвэл цагдааг өөрийг нь үү? Үүнийг шийдэхэд, хуулийн заалтуудын утга агуулга, холбогдох дүрэм журмууд, өмгөөллийг амжилтанд хүргэх магадлал, мөн эерэг шийдвэрийн нөлөөлөх байдал, төрийн ямар ажилтан, алба тухайн нөхцөл, бодлогыг өөрчлөх боломжтой эсэх зэрэг нь хариуцагчийг тогтооход анхаарч үзэх хүчин зүйлүүд болдог. Жишээ нь, байгаль орчны асуудалд гэхэд төр засгийн болон хувийн хэвшлийн аль нэгний эсвэл хоёулангийнх нь хийсэн ажиллагаа эсвэл хийх ёстой ч хийлгүй орхисноос болж учирсан хохирлын асуудал сөхөгддөг.

Болгарын хүний эрхийн төслөөр хэрэгжүүлсэн өмгөөллийн ажиллагаа: Цагдаагийн алба цыган иргэдтэй бүдүүлэг харьцаныхаа төлөө шийтгэл хүлээсэн нь

1995 онд, Болгарын Разардик дүүргийн шүүхээс Кирил Иорданов хэмээх 24 настай цыган залууд Дотоод хэргийн яамнаас 10000 лев төлөх шийдвэр гаргасан. Энэ нь тус дүүргийн цыганы сууринд хууль бусаар явагдсан ажиллагааны үеэр цагдаагийн ажилтны учруулсан бие махбодын гэмтлийн нөхөн төлбөр байлаа. Энэ хэрэг галт зэвсэг, бичиг баримтын үзлэг хийх нэрээр нутгийн цыгануудыг цагдаа нар "залхаан цээрлүүлэх" болсон 1992 оноос эхэлсэн байна. Гэмт хэрэг үйлдсэн цыгануудаас хариугаа авах зорилгоор олон арван цыган хүмүүсийг зодож, тэдэнтэй зүй бусаар харьцаж байсны нэг нь Иорданов байв. 1996 онд хүчин төгөлдөр болсон шүүх хурлын дээрх шийдвэр нь Софи хотын хүний эрхийн төслийн ахлах хуульч Илко Дмитровын 4 жил шахам хөдөлмөрлөсний үр дүн байлаа. Цагдаа нар хууль бус ажиллагаа хийхдээ нүүрээ багаар халхалдаг байсан учраас тэднийг таних боломжгүй байсан тул Дмитров уг хэргийн хариуцагчаар яамыг татсан байна. Нөхөн төлбөрийн мөнгөн дүн /тэр үеийн ханшаар 45 ам доллар/ өчүүхэн боловч уг хэргийн ач холбогдол нь маш их байлаа. Энэ хэрэг нь цагдаа нарт зодуулсан цыган хүнийг хамгаалсан анхны ялалт болсон ба Болгарын шүүх ийм зэрлэг ажиллагааг хаацайлахгүй гэдгийг хүч хэрэглэгчдэд анхааруулсан юм.

Шүүх хуралдаанд олон хариуцагч байж болдог гэдгийг санах хэрэгтэй. Анхан шатны шүүх ажиллагаанд тавьсан стратегийн өмгөөлөлд Засгийн Газар хариуцагч байх нь түгээмэл байдаг. Орон нутгийн удирдлага, засгийн газрын агентлагууд, анхан шатны төрийн байгууллагууд нь тухайн бодлогыг хэрэгжүүлэгчид байдаг. Компанийг хариуцагчаар татах нь нэг талаас ихээхэн нөлөөтэй байж болох ч нөгөө талаас тэд ялахын тулд хууль зүйн маш хүчтэй тактик боловсруулж, их мөнгө санхүү дайчилж ажиллах боломжтой гэдгийг санах хэрэгтэй. Хувь хүмүүсийг стратегийн өмгөөлөлд ихэвчлэн татдаггүй. Учир нь тэд санхүүгийн нөхөн төлбөр ч төлдөггүй, мөн бодлогыг шинэчлэхэд нөлөө үзүүлэх боломж бага байдаг. Иймээс хомс хүч, мөнгө санхүү зарцуулахад дүйх хариуцагч болж чаддаггүй.

Тохирох шүүхийг сонгох

Зарим хэргийг нэхэмжлэх шүүхийг сонгох боломжтой байдаг бөгөөд хэрэг ялах магадлал нь шүүх болгонд адилгүй байдаг. Хэдийгээр тухайн шүүгч хэрхэн хандахыг тааж мэдэхэд хэцүү ч аль болох ялагдах эрсдлийг багасгаж, амжилтын боломжийг ихэсгэх тийм шүүхийг сонгох хэрэгтэй. Жишээ нь, газар зүйн янз бүрийн байршилд ижил хэрэг гарсан бол аль нэг дүүргийн шүүхэд ялах илүү боломжтой байж болно. Иймээс дараах асуултуудад анхаарах хэрэгтэй. Үүнд: ямар шүүх, шүүгч хэргийг шүүх вэ, эерэг үр дүнд хүрэх боломж юу вэ, давж заалдах боломж байна уу, тухайн хэргээр шүүхэд гомдол гаргахад шаардлагатай зүйлс нь өөр шүүхэд ямар байна вэ /тухайлбал, хязгаарлагдмал байдлын хүрээ г.м/ зэргийг анхаарч үзэх хэрэгтэй. Жишээ нь, захиргааны болон бусад шүүхийн ажиллагаа ижил байж болох ч амжилт гарах боломж нь өөр өөр байж болно.

Өмгөөлөгчид мөн бүхий л шатны шүүхийн үзэл баримтлалыг ойлгож мэдэхийг оролдох хэрэгтэй ба тухайн шүүхэд нөлөөлдөг хүчин зүйлийг олж мэдэхийн тулд хуучин шийдвэрүүдийг түүхэн нөхцөл байдлаас нь авч үзэх хэрэгтэй.

Нотлох баримт цуглуулах

Стратегийн өмгөөллийн амжилт нь шүүхэд гаргах нэхэмжлэлийн чанараас хамаараад зогсохгүй нэхэмжлэгч талын

ОХУ-ын өмгөөллийн жишээ: Оршин суух бүртгэлийн хэрэг

ЗХУ-ын үед төрөөс иргэдийг улс орон дотроо чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан оршин суугчийн бүртгэл хэмээх маш хатуу бүртгэлийн тогтолцоотой байсан. Оршин суугаа газрыг нь тодорхойлсон бүртгэлийн дардсыг бүх иргэдийн дотоод паспорт дээр дардаг байжээ. Үүнгүйгээр иргэд ажил хийх, өрөө түрээслэх, сонгуульд оролцох, гэрлэх, хүүхдүүдээ сургуульд явуулах, нийгмийн тусламжийн хөтөлбөрт хамрагдах, амьдарч байгаа газартаа үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ авах боломжгүй байв.

1993 онд ЗХУ нуран унаж, Оросын засгийн газар иргэдэд чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг олгосон хууль баталсан. Энэ хуулиар тэмдэглэгээ хийх замаар бүх иргэдийг бүртгэхээр заасан байлаа. Мөн орон нутгийн удирдлагууд байнгын болон түр оршин суугчдын бүртгэл хийх эрхтэй байсан ба гэхдээ тэд иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж чадахгүй болсон байв.

Гэсэн хэдий ч, ОХУ-д орон нутгийн олон удирдлагууд хуулийн тэмдэглэгээ хийх шаардлагыг шинэ газар нутагт оршин суухаасаа өмнө авах албан ёсны зөвшөөрөл гэсэн байдлаар хэрэглэж байсан. Ийм зөвшөөрөлгүй гэдгээр нь иргэдийг орон нутгийн нийгмийн үйлчилгээнээс хүртэхийг хориглох нь хэвшил болсон төдийгүй хууль бусаар оршин суусан хэмээн торгууль оногдуулахаар сүрдүүлдэг байсан.

Учир нь 1993 оны хууль болон түүнийг хэрэгжүүлэх тухай зааварт ямар нэг байдлаар орон нутгийн удирдлагууд бүртгэхээс татгалзах боломж тавигдсан ба бусад хориглолт торгуулийг холбооны дүрэм, журмаар олгогдсон эрхийн дагуу хийсэн гэж удирдлагууд тайлбарласан.

1996, 1997 болон 1998 онуудад тус улсын Үндсэн Хуулийн шүүхээс иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан орон нутгийн тогтолцоо нь Үндсэн хуульд нийцэхгүй гэдэг талаар шийдвэр гаргасаар байсан байна. Анхны хэргийг Сибирийн Коми бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч болон хоёр иргэн хамтран Үндсэн хуулийн шүүхэд үүсгэсэн. Тэдний асуудал нь Орос улсын эдийн засгийн хувьд хөгжсөн бүс нутаг руу ядуу бүс нутгийн иргэдийг оруулахгүй байхын тулд бүртгэлийн тогтолцоо ашиглаж байна гэсэн баримтаас

үүдэлтэй байлаа. Шүүхээс тогтоосноор орон нутгийн төрийн албан хаагчид нь оршин суугчдыг бүртгэх зорилгоо умартаж, 1993 оны хуульд нийцэхгүй үйл ажиллагаа явуулж байна гэсэн байв. Гэвч Үндсэн Хуулийн шүүхийн шийдвэрийг эс тооцвол орон нутгийн албан хаагчид гаргасан шийдвэрт бага анхаарсан.

Шүүхээс гаргасан 1998 оны шийдвэрийн дараа, орон нутгийн удирдлагын түвшинд өөрчлөлт хийхийн тулд Үндсэн Хуулийн шүүхийн шийдвэрээс өөр илүү ихийг хийх хэрэгтэй гэдэг нь тодорхой болсон. Ингээд Москвад байрладаг Иргэний хамтын ажиллагаа ТББ нь бүртгэлийн хуулийг өөрчлөх кампанит ажил санаачилсан. ТББ нь хуулийг шууд өөрчилж чадахгүй учраас бүртгэлийн асуудлаас болоод эрхээ эдэлж чадахгүй байгаа болон торгуулсан иргэдийг төлөөлж ажилласан. Тус байгууллага шүүхэд хэрэг бүрдүүлэн өгч тэдгээр хэргүүдийнхээ хагасаас илүү хувьд нь ялалт байгуулсан. Бүх хэрэгтээ Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хэрэглэх асуудлыг гаргаж тавьж байв. Шүүхийн хэргүүд амжилттай шийдэгдэх тусам уг хуулийг өөрчлөхийг шаардсан олон нийтийн эсэргүүцэл нэмэгдэж байсан.

1999 онд иргэдийн эрхийг хуулиар зөрчсөн тохиолдолд ТББ-д гомдол гаргах эрх хуулиар олгогдсон. Ингэснээр, Иргэний хамтын ажиллагаа байгууллагаас шууд Москва дүүргийн шүүхэд бүртгэлийн ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэхгүй байгаа талаар гомдол гаргасан. 2000 оны 12 сард дүүргийн шүүхээс бүртгэлийн хууль нь Үндсэн хуульд нийцээгүй тул хүчингүй болгох шийдвэр гаргажээ.

Энэ шийдвэр нь бүртгэлийн ажиллагаанаас болж эрх нь зөрчигдсөн иргэдийн эрхийг хамгаалахад ихээхэн чухал нөлөө үзүүлсэн юм. Гэвч, Москва хотын захиргаа бүртгэлийн ажилтнуудад уг шийдвэрийг мэдэгдээгүйгээс захиргааны ажилтнуудад иргэд уг шийдвэр гарсан сонины хуудсыг үзүүлэхээс өөр аргагүйд хүрч байв. Иймээс стратегийн өмгөөлөл хийж ялалтанд хүрсэн ч уг шийдвэр хэрэгжиж байгаа эсэхэд байнгын хяналт хийх нь чухал юм. Гэсэн хэдий ч энэ хэрэг Оросын хүний эрхийн ажилтнуудын хувьд ихээхэн чухал үйл явдал болсон ба Оросын шүүхийн өсөн нэмэгдэж байгаа бие даасан байдал, Оросын хүний эрхийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварын өсөлтийг давхар илтгэсэн хэрэг болсон байна.

нотлох баримтын чанараас шалтгаална. Шаардагдах бүх нотлох баримтыг цуглуулахгүй бол онолын хувьд боломжтой хичнээн сайн хэрэг байсан ч бодит амьдрал дээр нотлогдохгүй байж болно.

Хуулийн заалтыг бүтээлчээр хэрэглэх

Төр засгийн байгууллага, түүний нэгжийг хэрэгт татах хуулийн даацтай үндэслэл гаргахын тулд хуулийг бүтээлчээр ашиглах үүний дотор практикт хэрэглэгдэж байгаагүй Үндсэн хуулийн болон олон улсын гэрээний заалтуудыг бүтээлчээр ашиглах хэрэгтэй байдаг. Ялгаварлан гадуурхалт, мэдээллийн эрх чөлөө, олон нийтийн оролцооны эрх, эрүүл орчинд амьдрах эрх зэрэгтэй холбоотой хариуцлага тооцох шинэ үндэслэл олох эсвэл хэрэг хянан

Европын Цыган иргэдийн эрхийг хамгаалах төвийн жишээ:

Энэ байгууллага нь цыган иргэдийг ялгаварлахтай холбоотой хэргүүдийг судалж өмгөөлөл хийдэг ТББ юм. 2000 оны 4 сард, тус байгууллага нь Чех улсын сэтгэцийн эмгэгтэй хүүхдийн тусгай сургуульд цыган хүүхдийн эрхийг Европын хүний эрхийн конвенцийн тодорхой заалтуудыг зөрчиж байгаа талаар Европын Хүний эрхийн хороонд хандаж хэрэг үүсгэсэн. Энэ ажиллагаагаар тус байгууллага хэд хэдэн бүтээлч шинэ үндэслэлийг гаргаж тавьсан байна. Нэгд, арьсны ялгаварлал нь өөрөө хүнлэг бус хандлага гэж үзсэн. Энэ үндэслэлийг батлахын тулд олон улсын гэрээний заалтууд болон уг Шүүхийн ажиллагаанд тулгуурласан байна. Энд тус байгууллага ялгаварлалын эсрэг зарчим бол Европын холбооны гол зарчим гэдгийг баримталсан. Ингээд, арьсны ялгаварлалыг хориглох нь шууд хэрэгжүүлэх ёстой хэм хэмжээ байдаг гэж нэхэмжилсэн. Үүнийгээ мөн олон улсын гэрээний заалтаар баталгаажуулсан байна. Мөн түүнчлэн, Европын хүний эрхийн конвенцид нэгдэгч талууд ямарч хүнлэг бус ажиллагаа гаргахгүй байх үүрэг хүлээсэн байдгийг гаргаж тавьсан. Үүнийгээ үндэстнээр ялгаварласан сургуультай холбоотой тоо баримтаар баталгаажуулсан байна. Тус байгууллага энэ хэргийг Чех улсын Үндсэн хуулийн шүүхэд нэхэмжлээд амжилтанд хүрч чадаагүй бөгөөд иймээс Европын хүний эрхийн шүүхэд тавиад байна.

шийдвэрлэх ажиллагаанд албан ёсоор хамрагдах зэрэг ажиллагааг ТББ-ууд хэрэглэж болно. Энэ стратеги нь үндэсний болон олон улсын шүүхэд гомдол гаргахад үр дүнтэй гэдэг нь батлагдсан юм.

Шүүгчдийг сургах, мэдээллээр хангах

Шүүгчид тухайн хэрэгт шийдвэрлэх үүрэгтэй байж болох олон улсын гэрээ болон үндсэн хуулийн болон холбогдох эрх зүйн талаар мэдлэггүй байж болно. Мөн хуулийн заалтыг бүтээлчээр хэрэглэх

Бангладешийн өмгөөллийн жишээ: Цацраг идэвхт бодис агуулсан хуурай сүүний хэрэг - Бангладешийн Худалдааны яамны Нарийн бичгийн газар болон бусад хүмүүсийн эсрэг доктор Мохиауддин Фарукийн үүсгэсэн хэрэг /1996/

1994 онд Бангладешийн Байгаль Орчны Хуульчдын Холбооны /БОХХ/ Ерөнхий нарийн бичгийн дарга хуульч доктор Мохиауддин өөрийн байгууллагын нэрийн өмнөөс болон нийтийн ашиг сонирхлын төлөө Бангладешийн Дээд Шүүхэд өргөдөл гаргасан. Тэр өргөдөлдөө 125 тонн импортоор оруулсан хуурай сүү нь Бангладешид зөвшөөрөгдөх хэмжээнээс их хэмжээний цацраг идэвхит бодис агуулсан тул түүнийг буцааж гаргах хүсэлт тавьсан. Энэ сүүг хуурамч бичиг баримтаар оруулсан байв.

Нэхэмжлэгчийн мэдүүлснээр, Төрийн албан хаагчид хяналт шалгалтын ажлаа хангалтгүй хийснээс болж Бангладешийн Үндсэн хуулинд заасан амьд явах эрхийг зөрчигджээ. Олон нийтийн эрүүл мэнд ноцтой аюулд учраад байгаа учраас БОХХ нь худалдан авагчийн хувьд болон олон нийтийн нэг хэсэг болохын хувьд уг гомдлыг үүсгэсэн гэж доктор Фаруук үзсэн байна.

Эхний удаад Дээд шүүхээс энэ хэргийг хэрэгсэхгүй болгосны дараа доктор Фаруук Давж Заалдах Шатны шүүхэд хандсан. Энэ удаад шүүх анх удаа хууль шүүхийн тогтолцоонд хүсэлтээ гаргах боломж багатай иргэдийн өмнөөс хэрэг үүсгэх боломжийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна. Тус шүүх Бангладешийн Үндсэн Хуулийн амьд явах эрхийн тухай заалтын тайлбарыг ихээхэн өргөн хүрээтэй болгожээ.

Энэ хэргийн явцын талаар БОЭХ-н ахлах хуульчдын нэг Есанул Хабиб хэлэхдээ “стратегийн өмгөөллийн дагуу шүүхэд мэдүүлсэн заргыг агуулгын бус үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон ч олон нийтийн байгаль орчны эрхийг хамгаалсан өмгөөллийн ажиллагаа нь оролцогч талуудад мэдлэг ойлголтыг бий болгож, нийгэмд үнэт зүйлсийг бүтээж байдаг. Ийм арга хэмжээ нь тодорхой зан үйлийн хүрээнд хязгаарлагдмал боловч өөрчлөлт авчирч, улмаар тэр нь эцсийн үр дүндээ маш чухал, зайлшгүй хэм хэмжээ болж тогтоход хүрч болно” гэсэн байна. Тэрээр мөн Бангладешийн хууль тогтоомжууд “хэрэгждэггүй,” бас “далд” байдаг ба төрийн албан хаагчид нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа огт хэрэгжүүлдэггүй гэсэн байна. 1994 оныг хүртэл Дээд Шүүхээс байгаль орчны талаар ямар ч шийдвэр гаргаж байгаагүй бөгөөд БОЭХ ийм хэргүүдийг гаргаж тавьсаар байна.

асуудлаар шүүгчдэд мэдээлэл, аргазүйн зөвлөмж хэрэгтэй байж болно. Олон улсын эрх зүйн талаар мэдээлэл багатай улс орнуудад холбогдох заалтыг хуульчдад олшруулж өгөх нь үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахаар дөхөмтэй ч байж болно. Жишээ нь, байгаль орчны асуудлаар сөхөгдсөн нэг хэргийг үүсгэсэн Оросын ТББ-аас 183 нэхэмжлэгчтэй хэргийг хүлээж авахуулахын тулд дүүргийн шүүгчидтэй уулзсан байна. Хуулиар бол ийм хэргийг шүүхэд нэхэмжилж болохыг заасан байсан ч өмнө нь ийм хэрэг шүүхэд ирж байгаагүй учраас шүүгчид уг хэргийг хүлээж авахаас татгалзаж байсан ажээ.

Гадны шинжээчийг оролцуулах

Гадны шинжээчид хуульчдын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Заримдаа шинжээч нар гэрчийн мэдүүлэг өгч болох ба эсвэл шинжээчийн бичсэн дүгнэлтийг шүүхэд танилцуулж болно. Энэ нь шинжилгээ судалгаатай холбоотой байдаг байгаль орчны асуудалд илүү хамаатай юм. Шүүх хуралдаанд шинжээчийн мэдүүлэг хийхийг зөвшөөрсөн журмыг ашиглан олон улсын эрх зүйн харьцуулсан хууль зүйн шинжилгээ хийдэг байгууллагын дүгнэлтийг мэргэшсэн ТББ-аар танилцуулж болно.

Унгар улсын хэрэг: Чернобылийн цацраг идэвхт бодисоос шалтгаалсан үхэл

1998 онд Байгаль орчны менежмент ба хуулийн холбоо нь тракторын жолоочийн бэлэвсэн эхнэрийн өмнөөс Будапешт хотын шүүхэд нэхэмжлэл гаргасан. Энэ хэрэг нь тэрхүү тракторын жолооч Чернобылийн атомын цахилгаан станцын тогооноос ялгарсан цацраг идэвхт бодисоос болж нас барсан явдалтай холбоотой байв. Хохирогчийн ажиллаж байсан Унгарын компанийг энэ хэрэгт хариуцагчаар татсан ба учир нь Чернобылийн дэлбэрэлт болсноос хойш 2 сарын дараа уг жолоочийг дэлбэрэлтээс үлдсэн тунадас бүхий газар луу томилж явуулсан бөгөөд тэгэхдээ жолоочид хамгаалалтын ямар нэг хэрэгсэл өгөөгүйгээр барахгүй түүнд учирч болох аюулын талаар анхааруулаагүй аж.

Унгарын шүүхээс хохирогчийн үхэл ба Чернобылийн цацраг идэвхт бодис хоёрын хооронд шууд холбоо байгааг анх удаа тогтоосон байна. Энэ хэрэг нь Унгарын шүүхээс Анагаах ухааны зөвлөлийн гаргасан шалтгаант холбоо байхгүй гэсэн дүгнэлтийг хүлээж авахаас татгалзсан хэдхэн тохиолдлын нэг болсон юм. Шүүх харин хохирогчийн эмчийн гаргасан дүгнэлт болон Анагаах ухааны сургууль зэрэг эмнэлгийн бусад байгууллагын шинжээчдийн дүгнэлтийг хүлээж авсан байна. Уг хэргийг хохирогчийн эхнэр болон хүүхдэд нь учирсан хохирлын хэмжээг тогтоолгохоор Хөдөлмөрийн шүүхэд шилжүүлсэн юм.

Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

Төрийн бус байгууллага болон иргэдийн бүлэг нь стратегийн өмгөөлөлд хамрагдаж байгаа бусад хүмүүсийн талаарх мэдээллийн үнэ цэнэтэй эх сурвалж болдог байна. Олон ТББ-ууд үндэсний болон олон улсын хүний эрх, байгаль орчны асуудал, угсаатны асуудал зэрэг янз бүрийн асуудлаар мэдээ баримт цуглуулдаг ба тэд өөрсдийн ажилладаг асуудлаар өмгөөллийн стратеги боловсруулахад тусалдаг. Мөн ТББ-ууд нь нэхэмжлэгчийг тодорхойлох, хэвлэл мэдээллээр нийтлэл мэдээ нэвтрүүлэх, өмгөөлөлтэй холбоотой олон нийтийн боловсролын ажиллагаа зохион байгуулж чаддаг.

Чернобылийн хэрэгт Крадле сангийн гүйцэтгэсэн үүрэг

Өмнө бичигдсэн Чернобылийн хэрэгт Байгаль орчны менежмент ба хуулийн холбоо нь Крадле сан хэмээх Будапештийн ТББ-тай хамтарч ажилласан юм. Энэ нь ТББ хэрхэн стратегийн өмгөөлөлд хувь нэмрээ оруулж болохын тод жишээ болж чадсан юм. Крадле сан нь Украинаас өвчтэй хүүхдүүдийг Унгарт хүргэж эмчлүүлэх зорилготой ажилладаг байгууллага байв. Уг сан их хэмжээний мэдээлэл цуглуулах ажиллагаа хийсэн байна. Тэд хэрэг явдлын тухай түүхэн мэдээлэл, хохирогчдын тоо баримт олох зэргээр шүүх ажиллагаанд хэрэгцээтэй зүйлд туслалцаа үзүүлсэн байна. Крадле сан нь нас барагсдын тоо, өвчтөнүүдийн тоо, цацрагийн хэмжээ, байгаль орчны байдлын тухай шинжилгээ судалгааны мэдээллийг олж, цуглуулж байв. Мөн Унгарын хэд хэдэн эмнэлгийн шинжээчидтэй холбоо тогтоож, тэдний нэг нь шүүх хуралдаан дээр мэдүүлэг өгсөн байна. Тэд осол болсны дараа 1986 оны 4 сард цацраг туяа хэрхэн хүний эрүүл мэндэд нөлөөлдөг тухай Украины засгийн газрын байр суурийг Унгарын засгийн газрын байр суурьтай харьцуулсан баримтыг олж чадсан нь ихээхэн үнэ цэнэтэй зүйл болсон юм.

Үндсэн хууль болон олон улсын гэрээнд түшиглэх

Зарим тохиолдолд, нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан өмгөөллийн ажиллагаанд хууль зүйн үндэслэлээ үндсэн хууль болон олон улсын гэрээнд тулгуурлаж гаргах нь амжилтанд хүрэх гол түлхүүр болдог. Үндэсний хууль эрх зүйн орчин нь хөгжөөгүй, хууль нь хэрэгждэггүй, эсвэл эрс өөрчлөгдөж байдаг орнуудад нийтийн ашиг сонирхлыг хамгаалахдаа үндсэн хууль эсхүл олон улсын эрх зүйг хэрэглэх нь илүү найдвартай арга зам байж болно. Шүүгчид нь үндэсний хууль тогтоомжийг тайлбарлахдаа тааруухан байдаг англо-саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад шүүгчдийн анхаарлыг Үндсэн хууль болон олон улсын эрх зүйд хандуулах нь үйлчилж байгаа хуулиудыг нааштай тайлбарлахад хүргэх үр дүнтэй арга болдог байна.

Ботсваны өмгөөллийн жишээ: Харьяатын асуудал, Юнити Доу-н эсрэг Ботсваны Ерөнхий Өмгөөлөгч

1984 онд батлагдсан Ботсваны Харьяатын тухай хуулийн 4-5-р хэсэгт хэрэв Ботсваны иргэн эмэгтэйн нөхөр нь Ботсваны иргэн биш бол тэр эмэгтэйн нөхөр, хүүхдэд Ботсваны иргэний харяалал олгохгүй байх тухай заалт орсон. Тэгтэл нөхөр нь Ботсваны иргэн, харин эхнэр нь иргэн биш тохиолдолд эмэгтэйчүүдэд тавьсантай ижил хориг байхгүй байв. Ингэж хүйсээр ялгаварласан байдал нь тус орны уламжлалт соёл болон жендерийн ялгаварлал шингэсэн эрх зүйн тогтолцоотой холбоотой байлаа. Юнити Доу нь Иргэншлийн хуулийн холбогдох заалтын эсрэг няцаалтаа эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, Ботсваны Үндсэн хуулийг зөрчсөн зэрэг хууль зүйн үндэслэлээр тавьсан байна. Улмаар Дээд шүүхээс уг хуулийг хувь хүний эрхийг зөрчсөн гэсэн шийдвэр гаргасан байна. Ингэж Дээд Шүүхээс эмэгтэйчүүдийг ялгаварлахын эсрэг хэм хэмжээг тогтоож мөнхүү, уг шийдвэрээ үндэсний болон олон улсын хууль тогтоомжуудад тулгуурлаж гаргасан учраас энэ нь цаашид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн өмгөөллийн ажиллагаа явуулах талбарыг бүрдүүлж өгсөн юм.

Мэргэжсэн хуулийн зөвлөхтэй зөвлөлдөх

Интерайтс, Европын цыган үндэстний хүний эрхийн төв, Хүний эрхийн олон улсын Хелсинкийн холбоо, Дэлхийн байгаль орчны хуулийн холбоо, E-Хууль, Эмнэсти Интернешнл, Байгаль орчны бүсийн төв зэрэг нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөх үйл ажиллагааны үнэ цэнэтэй мэдээлэл, туршлагыг хуримтлуулсан олон байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагын хуульчид холбогдох олон улсын гэрээний заалтууд болон тэдгээрийг хэрэгжүүлэх хэм хэмжээний талаар шинэ, чухал мэдээллийг түгээдэг. Тэд мөн шүүхэд нэхэмжилж байгаа хэргүүдийг бэлтгэхэд туслах, төлөөлөө явуулах, шүүхэд amicus curiae буюу “шүүхийн нөхдийн” мэдэгдлийг бэлтгэдэг.

Жишиг хэргийг хэрэглэх

Нэгэнт бүтээлч сэтгэлгээ, шинэлэг стратеги амжилтанд хүрвэл энэ нь цаашид үүнтэй ижил шийдвэрүүд гарах замыг засдаг. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын хувьд ч, хэдийгээр тухайн шийдвэр нь дараагийн хэрэгт хууль зүйн хувьд ямар ч нөлөөгүй боловч бусад шүүгчдийг төсөөтэй шийдвэр гаргахад үлгэр дууриал болдог. Жишээ нь, аль нэг муж дүүргийн нэр хүндтэй шүүгч өмнө хэрэглэж байгаагүй хуулийн заалтуудын хүрээнд нийтийн ашиг сонирхлын талд шийдвэр гаргасан бол энэ нь бусад шүүгчид ижил төстэй хэргүүд дээр шийдвэрээ гаргахад нөлөөлж болно. Мөн Үндсэн хуулийн шүүхээс хүний эрх, нийтийн ашиг сонирхолд хамаатай хэргүүдээр гаргасан шийдвэрийг авч үзэх боломжтой. Шүүхийн тогтолцоог өөрчилж, шинэчилж байгаа газруудад нийтийн ашиг сонирхлын асуудлаар шүүхийн байгууллагууд туршлага багатай байх нь зарим нэг хэргийн асуудлаар өмнөх шийдвэрүүдийг эргэн харахын үнэ цэнийг өмгөөлөгчид амжилттай ухуулан ойлгуулах ховор боломжийг олгоно. Түүнээс гадна, эх газрын эрх зүйн тогтолцоотой цөөн орнуудад шүүгчид өмнөх шийдвэрүүдийг эргэн харж шүүхийн шийдвэр гаргахдаа хэрэглэх нь улам нэмэгдсээр байна.

Олон улсын шүүхэд хандах

Өмгөөлөгч нар тухайн хэргийнхээ талаар олон улсын болон бүс нутгийн шүүхэд хандах боломжийг анхаарч үзэх ёстой. Гэхдээ олон улсын шүүхэд хандахын өмнө үндэсний хэмжээний арга замыг бүгдийг гүйцээх шаардлагыг хангасан байхыг анхаарах хэрэгтэй.

3.2. НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ МЕХАНИЗМИЙГ АШИГЛАХ НЬ

НҮБ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 1-д хүний эрхийг хамгаалах асуудлыг НҮБ-ын нэг зорилго болгон: “Эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн шинж бүхий олон улсын асуудлыг шийдвэрлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг яс үндэс, хүйс, хэл болон шашин шүтлэгээс үл хамааран дэмжиж тэтгэхэд олон улсын хамтын ажиллагааг чиглүүлэх” гэж заасан.

1948 оны 12 сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тэр үед оршин байсан улсуудын нийгэм, эдийн засгийн байгууламж болон хүний эрхийн соёл, шашин зэргийн ялгааг харгалзахгүйгээр бүх улс түмэнд хүний эрхийг хамгаалах салбарт хамтран ажиллах, хамтдаа эрмэлзэх түгээмэл зарчмуудыг зарлан тунхагласан. Эдгээр зарчмууд нь хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийг бүтээж, хөгжүүлэх эх сурвалж, үндсэн суурь нь болсон юм.

1966 онд Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пакт гэсэн хоёр конвенцийг батлан түгээмэл тунхаглалын зарчмуудыг хүний эрхийн салбар бүрээр тодорхой болгон хууль зүйн хүчин чадалтай олон улсын гэрээ болгосноор хүний эрхийн тухай олон улсын билль бүрдсэн юм. Үүнээс хойш НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас хүний эрхийн талаар 50 гаруй гэрээ, конвенциуд батлан гаргажээ.

Монгол Улс дээр дурдсан хоёр Пактад 1974 онд нэгдэн орсон бөгөөд түүнээс хойш хүний эрхийн тухай олон улсын 30 гаруй гэрээ, конвенцуудад нэгдээд байна. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт зааснаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр тул дотоодын хуулийн нэгэн адил үйлчлэх хууль зүйн хүчин чадалтай болжээ. Түүгээр ч барахгүй эрх зүйт төрийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ёсоор хэрэв тухайн улсын дотоодын хууль, олон улсын гэрээ хоёрын заалтын хооронд зөрчил байвал олон улсын гэрээний заалт давуу хүчинтэй үйлчлэх зарчмыг хүлээн зөвшөөрсөн улс болсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний эрхийн тухай асуудлыг олон улсын эрх зүйн стандартын орчин үеийн түвшинд нийцүүлэн хуульчилснаар Монгол Улсад хүний эрхийг хангах хууль зүйн баталгаа бий болсон юм. Гэхдээ хүний эрхийн тухай асуудал зөвхөн хуулиар тунхагласнаар биелэлээ олдоггүй учраас түүнийг хэрэгжүүлэх механизмаас эхлээд баталгааг бүрдүүлэхэд онцгой анхаарч идэвхитэй тэмцэх шаардлагатай⁸ хэмээн манай нэртэй хуульчид үзэж байна.

⁸ Г. Совд. Хүний эрх, хараат бус шүүх. Хүний эрхийн төлөв байдлын судалгааны онол арга зүй Улаанбаатар 2001

Хүний эрхийг хамгаалах НҮБ-ын Дүрмийн механизм

Дүрмийн механизм нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл болон НҮБ-ын дүрмээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа бусад байгууллагуудын тогтоол шийдвэрээс бүрдэнэ. Дээрхи байгууллагуудад НҮБ-ын Хүний эрхийн комисс, Хүний эрхийг ханган хамгаалах дэд комисс, Эмэгтэйчүүдийн байдлын комисс болон Хүний эрхийн дээд комиссарын газар ордог.

НҮБ-ын 1235 тоот тогтоол: Улс орнууын нөхцөл байдлын талаар нээлттэй хэлэлцүүлэг хийх

Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1967 оны 1235 дугаар тогтоол нь хүний эрхийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж байгаа улс орны асуудлыг НҮБ-ын Хүний эрхийн комисст, олон улсын хүрээнд ил тод хэлэлцүүлэх үндэс болдог. Анхаарал тавих шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөн улс орнуудын онцлог байдлыг тодорхойлох зорилгоор жил бүр Хүний эрхийн комиссын чуулганаар явуулдаг хэлэлцүүлэгт тухайн орны Засгийн газар болон ТББ тодорхой түвшинд оролцож болдог. Мөн энэхүү хэлэлцүүлэгт хүний эрх ноцтойгоор зөрчигдөж байгаа тодорхой нөхцөл байдлыг комиссоос сонгосон хувилбараар /судлах, илтгэл тайлан бэлтгэх, газар дээр нь шинжлэх гэх мэт/ судлан шинжилж байгаа Хороо болон Дэд хороог оролцуулдаг байна.

НҮБ-ын 1503 тоот тогтоол: Нууцаар шинжлэх журам

Энэ нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1967 оны 1235 дугаар тогтоолыг үндэслэн тус зөвлөлөөс 1970 онд гаргасан 1503 дугаар тогтоолоор батлагдсан журам юм. Энэ нь хүний эрхийг удаа дараа ноцтой зөрчсөн онцгой нөхцөл байдлыг судлах зорилгоор Нийгмийн цөөнхийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх болон хамгаалах НҮБ-ын дэд комиссоос эрхлэн явуулдаг, гэрээний бус журам, механизмууд юм. Эрх нь зөрчигдсөний улмаас хохирсон этгээд эсхүл зөрчлийн талаар шууд ба найдвартай мэдээлэл бүхий Засгийн газрын бус эх сурвалж /ТББ, бүлэг хүмүүс, хувь хүн/-аас бичгээр гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэх эрхийг энэхүү тогтоолоор дэд комиссд олгожээ.

Бүдүүвч 1. НҮБ-ын хүний эрхийг хамгаалах дүрмийн механизмын тойм

ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ

- Олон улсын шинж чанартай асуудлыг хэлэлцэхээр жилд нэг удаа намар чуулдаг Дэлхийн парламент гэж хэлж болох НҮБ-ын гишүүн орнуудын төлөөлөл бүхий НҮБ-ын үндсэн байгууллага юм
- Ерөнхий Ассамблейн шийдвэр нь эрх зүйн акт болохгүй
- НҮБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоодог



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЗӨВЛӨЛ ECOSOS

- 3 жилийн хугацаатайгаар сонгогдсон 54 гишүүнтэйгээр ажилладаг бөгөөд Хүний эрхийн комисс, Үндэстний цөөнхийг хамгаалах, ялгаварлан гадуурхахаас сэргийлэх асуудал эрхэлсэн дэд комисстэй бөгөөд эдийн засаг, нийгмийн хүрээний хүний эрхтэй холбогдолтой НҮБ-ын дүрмийн механизмтай холбоотой асуудлыг эрхэлдэг.
- ТББ-уудтай албан ёсны хамтын ажиллагааг үйл ажиллагаандаа дэмждэг



ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС

- ЭЗНЗ-ийн туслах байгууллага бөгөөд олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлыг зохицуулах, олон улсын стандартыг тогтоох гэрээ боловсруулах, тэдгээрийг батлах замаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
- Дэлхийн бүх бүс нутгийг төлөөлөхүйц улсуудын 53 гишүүнтэй
- НҮБ-ын хүний эрхийн асуудал эрхэлсэн хамгийн чухал институт бөгөөд гишүүн улсуудын хүний эрхийн байдлыг авч хэлэлцэн зөвлөмж гаргадаг.
- Илтгэгч, ажлын хэсэг томилох зэрэг гэрээнээс гадуур механизмыг бий болгодог.



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАН ХАМГААЛАХ ДЭД КОМИСС

- 26 бие даасан шинжээчээс бүрдэнэ.
- Хүний эрхийн тодорхой асуудлаар судалгаа хийнэ.
- ХЭКомисст хүний эрхийн тодорхой асуудлаар илтгэл бичиж, санал зөвлөмжийг боловсруулан өгдөг.

ТУСГАЙ ИЛТГЭГЧИД, АЖЛЫН БҮЛЭГ

- ЭЗНЗ, ХЭК-оос сонгогдсон шинжээчид байдаг
Хүний эрхийн тодорхой хүрээнд судалгаа шинжилгээ хийж илтгэл бичдэг. Илтгэгч нь тодорхой нэг орны асуудлаар \улс орны илтгэгч\, хүний эрхийн тодорхой нэг сэдвээр \сэдвийн илтгэгч\ гэсэн 2 хэлбэртэй байдаг.

НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт гаргах тэрхүү өргөдөл нь “дэд комиссийн ажил үүргийн хүрээнд хамаарах асуудал бөгөөд хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байгааг нотолсон байхаас гадна зөрчил хэвшмэл шинжтэй болсныг илчлэн гаргасан байх ёстой” гэж заажээ. Иймд мэдээллийн эх сурвалж нь зөвхөн ганц хохирогч байлаа ч түүний өргөдөлд, хохирогчид учирсан нэг хохирлын талаар бус харин удаа дараа давтагдсан, олон хүнийг хамарсан, олон зөрчлүүдийн талаарх мэдээлэл тусгагдсан байх ёстой гэсэн үг.

“Ноцтой зөрчил” гэсэн нэр томъёоны утгыг нэг мөр тогтоогоогүй ч түүнд геноцид буюу төрлөөр нь устгах, апартейд гэмт хэрэг, үй олноор цаазлах, эрүүдэн шүүх, боолчлох зэрэг хүний эрхийн хамгийн хүнд зөрчлүүдийг хамруулан ойлгодог. Дэд комисс нь тухайн зөрчил хэвшмэл шинжтэй болсон байна гэдгийг тогтоовол энэ талаар Хүний эрхийн комисст танилцуулах бөгөөд Хүний эрхийн комисс үүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно. Уг ажиллагаа нь дэлхийн аль ч улс орны эсрэг байж болох бөгөөд энэхүү асуудлыг нууц, хаалттай хурлаар хэлэлцдэг.

Хүний эрхийг хамгаалах НҮБ-ын Гэрээний механизм

Олон улсын гэрээ, пакт, конвенцууд нь хэлэлцэн тохирогч улс орнуудын хувьд эрх зүйн заавал биелэгдэх хүчин чадлыг агуулдаг. Иймээс Пактаар олгогдсон эрхийг эдлэх, түүнийг мөрдөхтэй холбоотой тэдний хоорондын асуудал нь олон улсын хэмжээний асуудал болох учраас улс орнуудын дотоод эрх мэдлийн асуудал байхаа болино.

НҮБ өөрийн баталсан гэрээ конвенцийг хэрхэн биелүүлж байгааг ажиглах, хянах, удирдан чиглүүлэх шүүхийн эсвэл хагас шүүхийн шинжтэй байгууллагыг /treaty body/ гэрээний хүрээнд үүсгэн байгуулжээ. Тэдгээр нь гэрээний биелэлтийг хангах зорилгоор улс орнууд ямар салбарт гэрээ, конвенцийг биелүүлэхгүй байгааг буюу нэг удаагийн зөрчлийг судлах, түүнчлэн оролцогч талуудаас гэрээний хэрэгжилтийн талаар илтгэл болон гомдол хүлээн авах замаар гэрээг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг улс орнуудад зөвлөмж болгодог байна. НҮБ-аас одоогоор батлан гаргаад байгаа 7 конвенцийн биелэлтийг хянах байгууллагыг байгуулан ажиллуулж байна. Үүнд:

1. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд батлан гаргаж, 1976 онд хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн.
2. Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд батлан гаргаж, 1976 онд хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн.
3. Арьс, өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын Конвенц 1969 онд хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн
4. Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах Конвенц 1991 онд хүчин төгөлдөр болж эхэлсэн.
5. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц
6. Хүүхдийн эрхийн тухай Конвенци 1990 онд хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн.
7. Цагаач ажилчдын болон тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах тухай Конвенц 2003 оноос хүчин төгөлдөр болсон.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс тэдгээр гэрээ конвенциор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа тухай тайланг НҮБ-ын Хүний эрхийн хороо болон бусад холбогдох хороодод удаа дараалан хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг хүлээж авч байжээ.

Харин хувь хүн, бүлэг, ТББ-уудаас гэрээний механизмыг ашиглах талаар хангалтгүй ажиллаж ирсэн байна. Засгийн газрын илтгэлд сүүдэр илтгэл бичих талаар иргэний нийгмийн туршлага бага байна. Монголын ТББ-ууд ЭЯГБХУК болон Хүүхдийн эрхийн хэрэгжилтээр тус тус 1 удаа сүүдэр илтгэл бичсэн байна.

3.3 НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛДАГ БАЙГУУЛЛАГА

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалан ажилладаг байгууллагууд нь нийгмийн сайн сайхан байдлын төлөө үндэслэгдэн байгуулагдаж, түүний тулд нарийвчлан тодорхойлсон

эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр ажилладаг. Байгууллагын эрхэм зорилго нь хэн бүхэнд ойлгомжтой тодорхойлогдсон байх ёстой.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалан ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааны эрхэм зорилго, түүний хүрээг боловсруулан гаргахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Байгууллагын эрхэм зорилго, уг зорилгын хамрах хүрээг маш тодорхой томъёолон гаргах хэрэгтэй бөгөөд мөн уг зорилгод хэрхэн хүрэх тухай тодорхой стратегийг нарийвчлан боловсруулах
- Сайн боловсруулсан боловч өргөн цар хүрээг хамарсан, нарийн төвөгтэй зорилтуудыг сонгохын оронд хүрч болохуйц, тодорхой хүрээний зорилтуудыг сонгон авч амжилттай хэрэгжүүлэхийг эрмэлзэх.
- Байгууллагынхаа хүчин чадалд тохирсон зорилтуудаа тодорхойлсны дараа түүнийг хязгаарлагдмал нөөц боломжоор хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх арга замаа тооцсон байх зэрэг болно.

Эрхэм зорилгыг цөөн үгээр оновчтой илэрхийлэх шаардлагатай бөгөөд энэ нь хүмүүст ойлгомжтой бууж, бусдаас ялгарах боломжийг олгодог. Үүнээс гадна байгууллагын эрхэм зорилгыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь бий. Энэ нь байгууллагын зорилгыг нийгмийн аливаа өөрчлөлттэй уялдуулах хэрэгтэй эсэх, эрхэм зорилгын хүрээнд боловсруулагдсан хөтөлбөрүүдийг өөрчлөн шинэчлэх эсэх, мөн эрхэм зорилгод төдийлөн хамаагүй зарим нэг хөтөлбөрүүдийг зогсоох, эсвэл өөр нэмэлт шинэ хөтөлбөрүүдийг шинээр боловсруулан хэрэгжүүлэх эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд тусладаг.

Түүнчлэн байгууллага нь өөрийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чанарын болон тоон үр дүнг үнэлэх үнэлгээний системтэй байх хэрэгтэй. Энэ үнэлгээний систем нь үйл ажиллагааны өрнөл, үр дүнгийн талаар мэдэх боломжийг олгоно. Сайн боловсруулсан эрхэм зорилго нь стратеги төлөвлөгөөтэй байдаг. Мөн стратеги шинжилгээг байгууллагын үйл ажиллагааны зорилготой нягт холбон байнга хийх нь чухал ач холбогдолтой.

Шүүхээр хамгаалах

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалж ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааны төрөл, ач холбогдол нь маш олон янз байдаг. Гэвч энэ төрлийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн цөм нь нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалан, хэрэгжүүлэхэд оршино. Тухайлбал, нийтийн эрх ашигтай холбоотой хэргүүдэд шүүх болон төрийн захиргааны байгууллагуудын өмнө нийгмийн бүлэг, хувь хүмүүсийн итгэмжилсэн төлөөлөгчөөр ажиллана. Үүний тулд байгууллага нь нийгмийн бүлэгт тодорхой хууль зүйн туслалцаа үзүүлэн ажиллах, шүүхийн үйл ажиллагаанд оролцон стратегийн өмгөөлөл хийдэг. Нийтийн эрх ашгийг стратегийн өмгөөлөл хийн хамгаалахдаа хуульч нь зөвхөн дотоод гадаадын үр дүнтэй практик мэдлэг, туршлагыг хэрэглэхээс гадна, стратегийн өмгөөлөл хийхтэй холбоотой өргөн хүрээний нийгэм, эрх зүйн асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй. Стратегийн өмгөөлөл хийх хуульч нь хууль зүйн арга хэрэгслүүдийг нарийн эзэмшсэн, энэ үйл ажиллагаатай холбоотой олон улсын туршлагыг бүтээлчээр ашиглах чадвартай байх ёстой.

Шүүхээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны хэв маягийг Глобал Райтс хэмээх хүний эрхийн олон улсын хуульчдын байгууллагын судалгааны дүнгээр харуулья.

1. Бодлогын чиглэлээр ажилладаг байгууллагууд: Нийгмийн шударга ёс, эрх зүйн онол, бодлогын хэрэгжилтийн байдлаас үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа тодорхойлон хэрэгжүүлдэг. Эдгээр зорилго, зорилтууд нь
 - Нийгмийн тэгш байдлыг хангах
 - Нийгмийн эмзэг хэсгийг чадваржуулах
 - Удирдлагын бүтцийг өөрчлөх
 - Ядуурлыг бууруулах
 - Засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх
 - Хүний эрхийн онолын чиглэлийг хөгжүүлэх
 - Улс төрийн бодлогын шинжтэй маргаан мэтгэлцээнийг өрнүүлэх
 - Иргэний нийгмийг хөгжүүлэх зэрэгт чиглэгддэг байна.

Энэхүү бодлогын чиглэлээр хийгдэж байгаа ажлууд нь нийтийн шаардлага, мөн ядуусын хэрэгцээнээс гарч байгаа бөгөөд өөрийнхөө төлөө санаачлага гарган ажиллаж байгаа хүмүүсийг хөгжүүлэх, нийгмийн өөрчлөлтийг хуулийн хүрээнд хийх зорилготой “хуульчдын ядууст өгөх өглөг”⁹ юм хэмээн хуульчид дүгнэж байна.

2. Уламжлалт чиглэл : Энэ төрлийн өмгөөллийн үйл ажиллагааг хийхдээ ямар нэгэн шалтгааны улмаас өмгөөлөл авч чадахгүй байгаа иргэн, хэрэг нь жишиг хэрэг болж болохуйц тодорхой ач холбогдол агуулж байгаа эсэх, мөн асуудал нь Үндсэн хуулийн хэмжээнд яригдах эсэх, нийгэмд хэвшсэн санаа бодолд нөлөө үзүүлж чадах эсэх зэрэг шалгуурыг ашиглаж хэргийг сонгодог байна.
3. Бүлгийн чиглэл : Эмэгтэйчүүд, цагаач ажилчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, уугуул нутгийн ард түмэн, хүүхэд, сураггүй алга бологсод, тахир дутуу хүмүүсийн бүлэг, мөн үндэстэн, ястан, арьс өнгө, шашны цөөнхийн бүлгийг хамгаалан ажиллана.
4. Нэг асуудлаар дагнан ажилладаг чиглэл : Зөвхөн нэг ашиг сонирхлын асуудлаар дагнан үйл ажиллагаа явуулах бөгөөд жишээ нь, хүрээлэн буй орчны асуудал, нөхөн үржихүйн асуудлуудтай холбоотой хэргээр ажиллах нь элбэг байна.
5. Эрх зүйн тогтолцоонд хүний эрхийн ойлголтыг өргөжүүлэх чиглэл : Хэн нэгэн хэрэгтнийг цаазаар авах ялаас хэлтрүүлэн туслаж чадаж байгаа бол өвчин болоод өлсгөлөнгийн улмаас амь насаа алдаж байгаа хүмүүсийн эрхийг шүүхээр хамгаалан хэрэгжүүлэх боломжтой гэж үздэг. Энэ чиглэлийн үйл ажиллагаанууд нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг иргэний болон улс төрийн эрхийн нэгэн адилаар шүүхийн тогтолцоогоор хамгаалан хэрэгжүүлэх явдлыг төлөвшүүлэхийг зорьдог байна.

Мэргэжилтний зөвлөгөө

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалж ажилладаг байгууллагууд нь тодорхой эрхийн чиглэлээр хөрөнгө оруулагчид,

⁹ Диокно, 2001

төрийн байгууллагууд, хууль тогтоогчид, судалгаа шинжилгээний ажилтнууд зэрэг үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх мэдлэг, туршлагыг хуримтлуулсан байдаг. Энэ үйл ажиллагаа нь захидал, илтгэл бичих хэлбэрээр хийгддэг бөгөөд мөн байгууллага оролцох боломжгүй хэргүүдэд аман хэлбэрийн зөвлөгөө өгч болдог. Байгууллага энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дуртай байдаг бөгөөд учир нь тухайн байгууллагын нэр төрийг олон нийт хүлээн зөвшөөрч буйг илэрхийлэхийн зэрэгцээ санхүүгийн муугүй эх үүсвэр болдог байна.

Хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх

Нийтийн эрх ашгийг хамгаалан ажилладаг олон байгууллагуудын зорилго нь хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад орших бөгөөд тэд хуулийн төслүүд, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг батлуулахын тулд лобби үйл ажиллагаа хийх, мөн батлагдан гарсан зарим хуулийн үйлчлэлийг зогсоох, хэрэгжүүлэхгүй байх эсэргүүцлийн компанийг өрнүүлэх зэрэг үйл ажиллагааг хийдэг. Мөн олон улсын байгууллагуудын анхаарлын төвд байгаа одоо хэрэглэгдэж байгаа хууль тогтоомжуудад шинжилгээ, мэргэжилтний үнэлгээг хийж болно. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалан ажилладаг хуульчид нь хэдийгээр олон улсын түвшинд шинжилгээ хийх эрх байхгүй ч өөрийн оронд хэрэгжиж байгаа хууль тогтоомжид дүн шинжилгээ хийн түүнийгээ тухайн байгууллагуудад илгээж болно. Учир нь олон улсын байгууллагуудад тухайн хууль тогтоомж улс орнуудад хэрхэн хэрэгжиж байгаа мэдээлэл ямагт хэрэгтэй байдаг бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хамгаалан ажилладаг байгууллагууд нь энэ боломжийг ашиглан үндэсний болон олон улсын хууль тогтоомжид харьцуулан шинжилгээ хийсэн тайландаа тэдний анхаарлыг хандуулж болно.

Сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх

Мэргэжлийн түвшний байгууллагуудын ажилтнууд, олон нийтийг гэгээрүүлэн сургахгүйгээр иргэний нийгмийн хөгжлийн асуудлыг ярих боломжгүй бөгөөд нийтийн ашиг сонирхлыг өмгөөлөн хамгаалах асуудлаархи боловсролын үйл ажиллагаа нь чухал ач холбогдолтой байдаг. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалан

ажилладаг байгууллагууд нь ямар нэгэн асуудлаар тодорхой бүлгүүдэд тухайлбал төрийн бус байгууллагууд, бизнесийн бүлгүүд, төрийн байгууллагууд, сайн дурын ажилтнууд, улмаар нийгэмд бүхэлд нь зориулсан боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байдаг. Мөн байгууллагууд нь олон нийтийг гэгээрүүлэх үйл ажиллагаанд өөрийн төлөөлөгчийг илгээх замаар энэ төрлийн үйл ажиллагаанд оролцдог. Зарим тохиолдолд ямар нэгэн мэдлэгийг олон нийтэд олгох далайцтэй сургалтын хөтөлбөрөөс татгалзах нь ч бий. Учир нь байгууллага ямар ч тохиолдолд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ өөрийн эрхэм зорилгыг харгалзан үздэг байна.

Хууль зүйн сургуулиудад хичээл заах, оюутнуудыг удирдан ажиллах

Нийтийн эрх ашгийг хамгаалан ажилладаг хуульчид өөрийн мэдлэг, туршлагаа залуу хуульчдад өвлүүлэн эзэмшүүлэхэд их анхаардаг. Энэ төрлийн үйл ажиллагаа нь хууль зүйн сургуулиудад мэргэжлийн тусгай лекц унших замаар ихэвчлэн хэрэгжих бөгөөд мөн их сургуулиудад хэрэгжиж буй клиник хөтөлбөрүүдэд оролцож, оюутны ажлыг удирдаж болно. Энэ нь уг хуульчдад ч их тустай бөгөөд байгууллагын хувьд төгсөх ангийн оюутнуудад туршлага олгож ирээдүйн хамтын ажиллагаандаа татан оролцуулах боломжтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэл дээр

1. Хүний эрхийн стратегийн нөлөөлөл: Туршлага ба амжилт семинар /Илтгэлүүдийн семинар/., Глобаль Райтс, Хүний Эрх Хөгжил Төв, Нээлттэй Нийгэм Форум., Улаанбаатар 2004
2. Монгол улс дахь Хүний Эрхийн төлөв байдал 2001., Улаанбаатар 2001
3. Хүний Эрхийн Олон Улсын Гэрээний Хэрэгжилтийн Талаархи Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодын тэмдэглэл, зөвлөмжүүдийн эмхтгэл., Эмхтгэсэн Ж. Дашдорж. ХЭХК., Улаанбаатар 2004
4. Төлбөрийн Чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь: Үндэсний бага хурлын эмхэтгэл, Хууль зүй дотоод хэргийн яам, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Улаанбаатар 2003
5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, туслалцааны хүртээмжтэй байдал” Судалгааны тайлан, НҮБХХ, ХЗДХЯ, МННФ, Улаанбаатар 2005
6. Хүний эрхийн төлөв байдлын судалгааны онол арга зүй., Монгол улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр боловсруулах төсөл., 2001
7. Мэргэжлийн сургалтын цуврал №5: Хүний Эрх хууль сахиулах нь: Цагдаагийн ажилтнуудад зориулсан гарын авлага. НҮБ., 2005
8. Эрх зүйн гэгээрэл Монгол Улсад., Судалгааны тайлан, Монгол дахь Азийн сан., Улаанбаатар 2004
9. Хүний Эрхийн төлөө Төрийн Бус Байгууллагуудын анхдугаар чуулга уулзалт: Илтгэл., Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төв., Улаанбаатар 2002
10. Нөлөөлөл гэж юу вэ?., Хүний эрх хөгжил төв, 2001 он

Англи хэл дээр

1. Edwin Rekosh, Kyra Butchko and Vessela Terzieva, Pursuing the Public Interest : A Handbook for Legal Professionals and Activists (New York : Public Interest Law Initiative 2001)
2. Edwin Rekosh, “Who Defines the Public Interest?” SUR ; PILI Paper No. 1 by Public Interest Law Initiative (Budapest 2005)
3. Richard J. Wilson, Jennifer Rasmussen (Researched by Scott Codey) Promoting Justice: A Practical Guide to Strategic Human Rights Law Lawyering., 2001
4. Many Roads to Justice: The Law-related Work of Ford Foundation Grantees Around the World., Ford Foundation. 2000